

# БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА, ХҮЙСИЙН БАРИМЖАА, ИЛЭРХИЙЛЛИЙН ТУХАЙ ХЭРХЭН БИЧИХ ВЭ?

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагад орсон “манин”, “хооцгон” хэмээх үг хэллэгээс бусад бүх үг хэллэгийг АНУ-ын Gay and Lesbian Alliance Against Defamation буюу GLAAD ([www.glaad.org](http://www.glaad.org)) хэмээх ЛГБТИК хүмүүсийн иргэний болон хүний эрхийн байгууллагаас 2016 оны 10-р сард шинэчлэн гаргасан GLAAD Media Reference Guide гарын авлагын аравдугаар хэвлэлтийг Монгол орныхоо нөхцөл байдал, үг хэллэгийн хэрэглээтэй уялдуулан эмхэтгэн орчуулав.

Энэхүү гарын авлагын гуравдугаар хэвлэлтийг Австралийн Засгийн газрын “Шууд тусламжийн хөтөлбөр”-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн #ЯлгаварланГадурхалтыгЗогсооё кампанит ажлын хүрээнд хэвлэсэн ба үнэгүй тараагдана.

"Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай хэрхэн бичих вэ? Хэвлэл мэдээллийн ажилтнуудын гарын авлага"-ын талаар тодруулах зүйл болон гарын авлагын талаарх санал хүсэлтээ ЛГБТ Төвийн [info@lgbtcentre.mn](mailto:info@lgbtcentre.mn) хаягаар ирүүлнэ үү. Гарын авлагыг хэвлэмэл байдлаар авахыг хүсвэл ЛГБТ Төвийн 70110323 утсаар холбогдоно уу.

УИИ.МН  
СУДАЛГААНЫ САН

**Орчуулагч**

Н. Анараа, Б. Эгшиглэн

**Эмхэтгэсэн**

“ЛГБТ Төв” ТББ, 2019 он

**Эх бэлтгэл**

Д. Эрдэнэбүрэн

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

- Лесбиян / Гей / Бисексуал / Күйр.....4
- Трансжендэр.....11
- Нэр төлөөний үг болон тодорхойлолт.....14

### **Хэрэглэхээс зайлсхийвэл зохиx үг хэллэг**

- Лесбиян / Гей / Бисексуал / Күйр.....7
- Нэр төрд халдсан, гутаан  
доромжилсон үгс.....10
- Трансжендэр.....15

### **АНХААРВАЛ ЗОХИХ**

- Ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль ба  
ЛГБТИК хүй олон.....17
- Гэрлэлт ба хүүхэд өсгөх тухай.....20
- Хүүхэдтэй болох, хүүхэд өргөж авах  
тал дээр хийсэн судалгаа.....21
- Шашин шүтлэг ба сүсэг бишрэл.....24
- Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг.....26
- (ӨӨС) ба (ӨДС).....28
- “Өөрчлөх эмчилгээ” .....30
- Спорт дахь ЛГБТИК хүмүүс.....32

- **ЛГБТ Төвөөс орчуулж эрхлэн  
гаргасан бусад материалууд.....35**

### **Бэлгийн чиг баримжаа**

Бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд аль нэг, эсвэл аль аль хүйсийн хүмүүст татагдах төрөлхийн мөн чанарыг бэлгийн чиг баримжаа гэнэ. Бэлгийн чиг баримжаа гурван төрөл байдаг.

Үүнд: гетеросексуал буюу эсрэг хүйсийнхээ хүмүүст татагддаг бэлгийн чиг баримжаа (стрэйт), лесбиян, гей буюу ижил хүйсийнхээ хүмүүст татагддаг бэлгийн чиг баримжаа, бисексуал буюу аль аль хүйсийн хүмүүст татагддаг бэлгийн чиг баримжаа багтана. Бэлгийн чиг баримжаа нь төрөлхийн ба өөрчлөгдөшгүй тул өөрчлөгдөх шинж чанартай гэсэн утгыг агуулдаг “хандлага”, уруу татагдах боломжтой гэж ойлгогдох олдмол хэмээх үгсийг хэрэглэхээс зайлсхийх ёстой. Хүн бэлгийн чиг баримжаагаа мэдэхэд бэлгийн хавьталд орсон байх шаардлага огт байхгүй.

### **Гей**

Бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд ижил хүйсийнхээ хүмүүст татагддаг хүмүүсийг тодорхойлдог тэмдэг нэр. Жишээ нь, гей залуу, гей хүмүүс. Эмэгтэй хүмүүсийн хувьд лесбиян гэдэг нэр үг ба тэмдэг нэрийг хэрэглэх нь тохиромжтой ба гей гэдэг үгийг ч мөн хэрэглэдэг. Гомосексуал гэдэг үгийг хэрэглэхээс зайлсхийх ёстой, учир нь олон лесбиян, гей хүмүүс үүнийг сөрөг утгатай ба доромжлолын өнгө аяс агуулсан хэмээн үздэг.

### **Лесбиян**

Бие махбод, хайр дурлал, сэтгэл зүрхний хувьд эмэгтэй хүмүүст татагддаг хүмүүс. Зарим лесбиян хүмүүс өөрийгөө тодорхойлохдоо гей гэдэг үгийг хэрэглэдэг. Лесбиян хүмүүсийг гомо, эсвэл гомосексуал хэмээн нэрлэх ёсгүй. *(Буруу хэрэглэхээс зайлсхийх ёстой үгсийн жагсаалтыг харах)*

### **Бисексуал**

Бие махбод, хайр дурлал, сэтгэл зүрхний хувьд эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хүмүүст татагддаг хүмүүс. Бисексуал хүмүүс аль аль хүйсийн хүмүүстэй бэлгийн хавьталд орсон ч байж болдог, үгүй ч байж болдог. Бисексуал хэмээн өөрийгөө тодорхойлохын тулд бэлгийн хавьталд орсон байх шаардлагагүй. Бисекс гэдэг товчилсон үг байддаггүй учраас битгий хэрэглээрэй.

### **Күйр**

Түүхийн хувьд энэ үг нь анх доромж утгаар хэрэглэгддэг байсан ч цаг хугацааны явцад ЛГБТИК хүмүүс энэ үгийг өөрийгөө бахархалтайгаар илэрхийлэх үг болгож чадсан юм. Хэдий тийм ч бүх ЛГБТИК хүмүүс энэхүү нэр томьёог өөртөө хамаатуулан ашигладаггүй болохыг мөн анхаарах ёстой. Ихэвчлэн энэ нэр томьёог бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжааг хоёрхон туйлт гэж үздэггүй ЛГБТИК хүмүүс хэрэглэдэг.

### **Трансжендэр, Транссексуал**

*( тэддүгээр хуудсыг харна уу)*

## **ЛГБТИК**

Лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, күйр гэсэн үгсийн товчлол. ЛГБТИК хэмээх товчлол нь бэлгийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог ба хэрэглэхдээ хүмүүсийг төөрөлдүүлэхгүйн тулд заавал бүрэлдэхүүн үгсийг тайлбарлах нь зүйтэй. “Гей олон нийт” гэх нь олон нийтийн ялгаатай байдлыг илэрхийлж чадахгүй учраас “ЛГБТИК олон нийт” гэж хэрэглэх нь зүйтэй.

## **Интерсекс**

Биологийн хүйс нь эм, эр аль болох нь тодорхойгүй байдлыг интерсекс гэнэ. Ген, гормон ба анатомийн олон шалтгаанаас үүдэн хүний хүйс тодорхойгүй байж болдог. Жишээ нь Клайнфелтеры синдром. Эцэг эх болон эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүс хүүхэд төрсөн даруйд түүний хүйсийг эр эмийн аль болохыг шийдэж, зөвхөн тэр хүйст нь хамаарах шинж тэмдгийг нь үлдээн, нөгөө хүйсийн шинж тэмдгийг нь хагалгаагаар авч хаядаг. Насанд хүрсэн олон интерсекс хүмүүс ийм үйл ажиллагааны эсрэг дуу хоолойгоо өргөж байгаагаас үүдэн хүүхдийг нялхад нь ийм мэс ажилбар хийхээ зогсоосон. Интерсекс гэдэг нь трансжендэр гэсэн үгтэй ижил утгатай үг биш ба энэ хоёр үгийг хооронд нь хольж хэрэглэхээс сэргийлээрэй.

## **Гетеросексуал**

Бие махбод, хайр дурлал, сэтгэл зүрхний хувьд эсрэг хүйсийн хүмүүст татагддаг хүмүүс. *(Стрэйт гэдэг үгийг харах)*

## **Гомосекс, гомосексуал, гомо**

*(буруу, хэрэглэхээс зайлсхийх ёстой үгсийн жагсаалтыг харах)* Клиникийн утгаар хэрэглэгддэг байсан хуучны энэ үг нь ихэнх лесбиян, гей хүмүүсийн хувьд сөрөг, доромжлолын утгатай байдаг. Ассошиэтед Пресс, Нью Йорк Таймз, Вашингтон Пост нь энэ үгийн хэрэглээг хязгаарласан байдаг. Ижил хүйсийн хүмүүст татагддаг хүмүүсийг лесбиян, эсвэл гей гэх нь тохиромжтой.

## **Гомофоби**

Лесбиян, гей хүмүүсээс айх айдас. ЛГБТИК хүмүүсийг үзэн ядах, үл ойлгох байдлыг ялгаварлан гадуурхалт хэмээн мөн тодорхойлдог.

## **Бифоби**

Ихэнхдээ үнэнч бус, завхай, бэлгийн замын халдварт өвчин тараагч гэсэн буруу, хэвшмэл ойлголтоос үүдэн бисексуал хүмүүсээс айх айдас. Бисексуал хүмүүсийг үзэн ядах, үл ойлгох байдлыг ялгаварлан гадуурхалт хэмээн мөн тодорхойлдог.

## **Өөрийгөө нээлттэй илэрхийлэх**

Өөрөө өөрийгөө хүлээн зөвшөөрөх насан туршийн үйл явц. Хүмүүс лесбиян, гей, бисексуал, трансжендэр байдлаа анхлан өөрөө өөртөө хүлээн зөвшөөрч, дараа нь хүмүүст хэлж болдог. Өөрийн бэлгийн чиг баримжааг бусдад хэлэх нь өөрийгөө илэрхийлэх үйл явцын нэг хэсэг байж ч болдог, үгүй ч байж болдог.

**Нээлттэй гей, нээлттэй лесбиян, нээлттэй бисексуал, нээлттэй трансжендэр хүн**

Хувийн, олон нийтийн, мэргэжлийн амьдралынхаа хүрээнд өөрийгөө лесбиян, гей, бисексуал, трансжендэр хэмээн нээлттэй тодорхойлдог хүмүүсийг нэрлэх үг.

Илчлэх: Цуу яриа, хардалт сэжигт үндэслэн хэн нэгний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг тухайн хүний зөвшөөрөлгүйгээр бусдад зарлан тунхаглах үйлдэл. ЛГБТИК хүмүүсийн ихэнх нь үүнийг хүлээн зөвшөөршгүй гэж үздэг.

**Амьдралын хэв маяг**

*(буруу, хэрэглэхээс зайлсхийх ёстой үгсийн жагсаалтыг харах)* ЛГБТИК хүмүүсийг үгүйсгэдэг хүмүүсийн ЛГБТИК амьдралыг үгүйсгэхийг оролдсон буруу нэр томьёо. Нэг л төрлийн гетеросексуал амьдралын хэв маяг байдаггүйтэй адил нэг л төрлийн лесбиян, эсвэл гей, эсвэл бисексуал, эсвэл трансжендэр амьдралын хэв маяг байдаггүй.

**Иргэний гэр бүлийн холбоо**

Лесбиян, гей хосуудыг төрөөс хүлээн зөвшөөрсөн, гэрлэсэн хосуудад өгдөг тодорхой хамгаалалт, зарим эрх үүргийг олгодог гэрлэлтийн нэг хэлбэр.

**Нуугдмал**

Өөрийн бэлгийн чиг баримжааны тухай бусадтай нээлттэй байдаггүй хүн.

**Иргэний хамтын амьдрал**

Хоёр хүний хоорондох бие биедээ үнэнч байхыг дээдэлсэн гэрлэлтийн нэг хэлбэр ба гэрлэлтийн зарим эрх үүргийг ийм төрлийн гэрлэлтэд төрөөс олгодог.





ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ	ХЭРЭГЛЭХЭД ЗОХИМЖТОЙ
<p><b>“гомосекс”, “гомосексуал”, “гомо”</b></p> <p>Гомосексуал гэдэг клиник үгийг 1970-аад онд Америкийн сэтгэлзүйчдийн холбоо, Америкийн сэтгэцийн эрүүл мэндийн холбоо хэрэглэдэг байсан түүхээс үүдэн ЛГБТИК хүмүүсийг өвчтэй, сэтгэлзүйгээрээ эрүүл бус гэж харагдуулахын тулд тэдний эсрэг тэмцэгчдийн ихэвчлэн хэрэглэдэг. Энэ үгийн хэрэглээг зөвхөн хүний хэлсэн үгийг эшлэхдээ хэрэглэхээр хязгаарлана уу. Гей, лесбиян гэдэг үгийг олон удаа давтахгүйн тулд гомосексуал гэдэг үгээр орлуулахаас татгалзана уу. Ассошиэтед Пресс, Нью Йорк Таймз, Вашингтон Постын найруулга, цэг таслалын гарын авлага гомосексуал гэдэг үгийн хэрэглээг зөвхөн тодорхой тохиолдолд хэрэглэхээр хязгаарласан байдаг.</p>	<p><b>“гей” (тэмдэг нэр); “гей эрэгтэй” эсвэл “лесбиян” (нэр үг); “гей хүн”; “гей хүмүүс”</b></p> <p>Ижил хүйсийнхээ хүмүүст татагддаг хүмүүсийн тухай бичихдээ гей, эсвэл лесбиян гэсэн үгийг хэрэглэнэ үү.</p>
<p><b>“бэлгийн чиг хандлага”</b></p> <p>Бэлгийн чиг хандлага хэмээх үг нь лесбиян, гей, бисексуал байх нь сонголтын асуудал ба эдгэрч болно, эдгээх ёстой гэсэн агуулгыг илтгэдэг учраас хэрэглэхээс зайлсхийх ёстой.</p>	<p><b>“бэлгийн чиг баримжаа” эсвэл “чиг баримжаа”</b></p> <p>Бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд аль нэг, эсвэл аль аль хүйсийн хүмүүст татагдахыг бэлгийн чиг баримжаа гэдэг үгээр илэрхийлэх нь илүү оновчтой ба энэ нь дотроо лесбиян, гей, бисексуал, стрэйт эмэгтэй эрэгтэй хүмүүсийг багтаадаг.</p>



**“гомосексуал харилцаа”,  
“гомосексуал хос”,  
“ижил хүйстэн хос”  
“ижил хүйстэн гэр бүл”,  
“гомосексуал хавьтал”**

Ижил хүйсийн хосыг гомосексуал хос, тэдний харилцааг гомосексуал харилцаа, тэдний дотно янаг харилцааг гомосексуал хавьтал хэмээн тодорхойлох нь маш сөрөг утга агуулдаг тул хэрэглэхээс татгалзах ёстой. Энэхүү үгийг ЛГБТИК хүмүүсийг доромжлох, ижил хүйсийн хосууд болон ижил хүйсийн харилцааг үгүйсгэх зорилгоор ЛГБТИК хүмүүсийн эсрэг тэмцэгчид ихэвчлэн хэрэглэдэг

**“харилцаа”,  
“хос”(шаардлагатай бол  
гей хос, лесбиян хос, ижил  
хүйсийн хос), “бэлгийн  
харилцаа”**

Ихэнх тохиолдолд танай уншигч, үзэгч, сонсогч ярьж буй хүмүүсийн нэр, тухайн хосын харилцааны тухай дүрслэл, төлөөний үгийн хүйсээр яригдаж буй хүмүүсийн бэлгийн чиг баримжаа, тэдний хүйсийг мэдэх боломжтой байдаг. Тиймээс хүмүүсийн харилцааг бэлгийн чиг баримжаагаар нь тодорхойлдоггүйтэй адил зарчмын дагуу аливаа үйл ажиллагаа, сэтгэл хөдлөл, харилцааг гей, лесбиян, эсвэл бисексуал хэмээн тодорхойлохоос татгалзах хэрэгтэй.

**“ЛГБТИК амьдралын хэв маяг”, “ЛГБТИК амьдралын хэв маяг”, “гомосекс амьдралын хэв маяг”, “гомосексуал амьдралын хэв маяг”**

Зөвхөн нэг л төрлийн лесбиян, эсвэл гей, эсвэл бисексуал амьдралын хэв маяг гэж байдаггүй. Лесбиян, гей, бисексуал хүмүүс амьдралын хувьд янз бүрийн байдлаар амьдардаг. “ЛГБТИК амьдралын хэв маяг” гэдэг томъёолол нь тэдний бэлгийн чиг баримжаа сонголтын асуудал ба түүнийг “эдгэрч болно”, “эдгээх ёстой” гэсэн агуулгыг илтгэдэг учраас хэрэглэхээс зайлсхийх ёстой.

**“лесбиян хүмүүсийн амьдрал”, “гей хүмүүсийн амьдрал”**

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

### **“гомочуудын асуудал”**

Энэ нь ЛГБТИК хүмүүсийн эсрэг тэмцэгчдийн хэрэглэдэг томъёолол юм. ЛГБТИК хүмүүсийн эсрэг тэмцэгчдийн үзэж байгаагаар ЛГБТИК хүмүүс эрх тэгш байдлынхаа төлөө тэмцэх нь “цаг нь болоогүй зүйл”, эсвэл “даварсан зүйл, даварсан хэрэг” хэмээх сөрөг уур амьсгалыг нийгэмд бүрдүүлэх зорилготойгоор хэрэглэдэг томъёолол мөн учраас хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.

ЛГБТИК хүмүүс нь монгол хүн бүртэй адил ажил хөдөлмөр эрхлэх, аюулгүй байх, эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах, хайртай хүмүүстэйгээ хамт байх, тэднийгээ асран хамгаалахыг хүсдэг эгэл хүсэл мөрөөдөл, зовлон жаргалтай хүмүүс. Үл ялгаварлах асуудлаар зөвхөн ЛГБТИК хүмүүстэйгээ нэгдэн үйл ажиллагаа явуулаад зогсохгүй, ийм төрлийн ялгаварлалд өртөж буй бусад нийгмийн бүлэг, давхаргатай хамт эрх тэгш байдлын төлөө тэмцдэг. ЛГБТИК хүмүүсийн тухайлсан тодорхой асуудлыг тодорхой илэрхийлэх хэрэгтэй. Жишээ нь, ЛГБТИК хүмүүсийг үл ялгаварлах асуудал, ЛГБТИК хүмүүсийн эсрэг гарч буй үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн асуудал гэх мэт.

### **“онцгой эрх”, тусгай эрх”**

### **“тэгш эрх”, “ тэгш хамгаалалт”**

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



## **НЭР ТӨРД ХАЛДСАН, ГУТААН ДОРМЖИЛСОН ҮГС**

### **“Гомо”, “гомосекс”, “лесби”, “шуумар”, “банди”, “цэнхэр”, “ягаан”, “хооцгон”, “саармаг” гэх мэт**

Аливаа бүдүүлэг үгийг үл хэрэглэх зарчмыг эдгээр үгэнд ч мөн хамаатуулах ёстой. Хэрэв аливаа хүн эдгээр үгийг хэрэглэвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл тухайн нэр төрд халдсан үгийг хөхиүлэн дэмжихгүйн тулд сурвалжлагч, сэтгүүлч, тоймч “Тэрээр ЛГБТИК хүмүүсийг доромжилсон үг хэрэглэв” хэмээн хашилтанд оруулбал зохино.

### **“Гаж дон”, “гаж донтон”, “бэлгийн гаж дон”, “бэлгийн гаж донтон”, “бэлгийн гаж зуршил”, “бэлгийн гаж зуршилтан”, “өвчтэй”, “өөрчлөлттэй”, “мэдрэл муутай”, “сэтгэцийн гаж өвчтэй” гэх мэт**

Лесбиян, гей, бисексуал байх нь сэтгэцийн эмгэг биш гэдгийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 1990 оны 5-р сарын 17-нд тодорхойлсон. Эдгээр болон төстэй үгийг хэрэглэх нь ЛГБТИК хүмүүс ямар нэгэн байдлаар хүнээс дорд, хүн бус, сэтгэцийн өвчтэй, ямар нэгэн байдлаар нийгэмд аюул учруулах хүмүүс гэсэн утгыг илэрхийлдэг. ЛГБТИК хүмүүсийн тухай бичихдээ эдгээр болон төстэй үг хэллэгийг хэрэглэх ёсгүй. Хэрэглэхээс өөр аргагүй бол тухайн үгийг хэрэглэсэн хүн ЛГБТИК хүмүүсийг ялгаварлан гадуурхдагийг харуулах зорилгоор л хашилтанд оруулан хэрэглэж болно. ЛГБТИК хүмүүс болон тэдний харилцааг хүүхэд уруу татах, хүүхдийг бэлгийн хувьд мөлжих, бусад бэлгийн мөлжлөг, ан араатантай хавьтах, бигами, полигами, үнэнч бус байдал, өөрийнхөө хүүхдийг бэлгийн хувьд хүчирхийлэх гэмт хэрэгтэй холбох үг хэллэг, утгыг илэрхийлэхээс зайлсхийх. ЛГБТИК байх нь эдгээр үзэгдэлтэй ямар нэгэн байдлаар холбоогүй. Эдгээр үг хэллэгийг ЛГБТИК хүмүүсийн хувьд хэрэглэх нь ЛГБТИК хүмүүс бол нийгэм ба гэр бүл, ялангуяа хүүхдүүдэд аюултай, “хүн бус” хүмүүс хэмээн харагдуулах зорилготой байдаг. Иймэрхүү зүйлийг хэлэх, бичих, сурталчлах нь нэр төрд халдсан үйлдэл болох ба ямар нэгэн байдлаар хүлээн зөвшөөршгүй. Зөвхөн тухайн зүйлийг хэлсэн хүн ЛГБТИК хүмүүсийг ялгаварлан гадуурхадгийг харуулах зорилгоор л хашилтанд оруулан хэрэглэж болно.

ОУЛАН  
СУДАЛГААНЫ САН

### Хүйс

Хүмүүсийг эм, эр хэмээн ялгах ангилал. Хүүхэд төрөхөд түүний бие махбодын өгөгдөл болох хромосом, гормон, нөхөн үржихүйн дотоод ба гадаад эрхтэнд үндэслэн түүний хүйсийг тогтоодог.

### Хүйсийн баримжаа

Охин эсвэл хүү, эмэгтэй эсвэл эрэгтэй гэдгээ мэдрэх хүний дотоод мэдрэхүй. Трансжендэр хүмүүсийн өөрийгөө мэдрэх, өөрийгөө тодорхойлох хүйс нь тэдний төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэй нийцдэггүй

### Хүйсийн илэрхийлэл

Хүний хүйсийн баримжааны гадаад илэрхийлэл. Энэ илэрхийлэл нь хүн биеэ авч явахдаа ихэвчлэн эмэгтэйлэг, эрэгтэйлэг эсвэл хүйсийг нь тодорхойлох боломжгүй байдлаар илэрхийлж буй байдлууд болох хувцаслалт, үс засалт, хоолой болон бие махбодын шинж тэмдгээр илэрдэг. Ихэвчлэн трансжендэр хүмүүс хүйсийнхээ илэрхийллийг төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэйгээ бус, өөрийгөө мэдэрч буй дотоод хүйсийнхээ мэдрэмжтэйгээ нийцүүлэхийг хичээдэг.

### Бэлгийн чиг баримжаа

Хувь хүний хэн нэгэнд бие махбод, хайр дурлал, сэтгэл санаагаар татагдах үзэгдэл. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл нь ижил зүйл биш. Трансжендэр хүмүүс стрэйт, лесбиян, гей, бисексуал байж болдог. Жишээ нь, эрэгтэйгээс эмэгтэй хүйс рүү шилжсэн трансжендэр эмэгтэй бусад эмэгтэйчүүдэд татагддаг бол өөрийгөө лесбиян, эсвэл бисексуал хэмээн

тодорхойлдог. Харин эмэгтэйгээс эрэгтэй хүйс шилжсэн хүмүүс бусад эмэгтэйчүүдэд татагддаг бол өөрийгөө стрэйт хэмээн тодорхойлдог.

### Трансжендэр

Өөрийн хүйсээ төрөхөд тэмдэглэгдсэн хүйсээсээ өөрөөр тодорхойлдог, эсвэл илэрхийлдэг хүмүүсийг хамарсан, тэмдэг нэрээр хэрэглэгддэг нэгдсэн нэр томьёо. Энэхүү нэр томьёонд дараах хүмүүс багтах ба эдгээр хүмүүсээр хязгаарлагдахгүй. Үүнд: транссексуал, трансвестит болон бусад хүйсийн хувьд төрөхөд тэмдэглэгдсэн хүйсээсээ өөрөөр өөрийгөө илэрхийлдэг, тодорхойлдог хүмүүс багтана. (ж. нь: жендэркүйр, нонбайнари, жендэрфлүид, ажендэр г.м) Трансжендэр хүмүүс ихэвчлэн эрэгтэйгээс эмэгтэй трансжендэр, эмэгтэйгээс эрэгтэй трансжендэр гэж өөрсдийгөө тодорхойлдог. Транс хүмүүсийн тухай бичихдээ тэдний өөрийгөө илэрхийлж, тодорхойлдог хүйсээр нь бичээрэй. Трансжендэр хүмүүс хүйсээ дааврын эсвэл мэс заслын аргаар шилжүүлэхийг сонгож ч болдог, сонгохгүй ч байж болдог.

### Транссексуал

Даавар болон мэс заслын тусламжтайгаар өөрийн хүйсийн баримжаандаа нийцүүлэн анхдагч болон хоёрдогч хүйсийн хэв шинжээ өөрчлөн өөрийн бие галбирыг эмэгтэйлэг эсвэл эрэгтэйлэг болгохыг зорьж буй хүмүүсийг илэрхийлдэг анагаахын мэргэжилтнүүдийн дунд голчлон хэрэглэгддэг нэр томьёо юм. Зарим транссексуал хүмүүс энэхүү нэр

томьёог хэрэглэсээр байдаг ч ихэнх трансжендэр хүмүүс транссексуал гэхээсээ трансжендэр гэдэг нэр томьёог хэрэглэдэг болсон. Транссексуал гэдэг нь трансжендэртэй адил өргөн хүрээтэй нэр томьёо биш, учир нь олон трансжендэр хүмүүс өөрсдийгөө транссексуал хэмээн тодорхойлдоггүй. Аль нэр томьёог хэрэглэхийг хүсч буй талаар хувь хүнээс өөрөөс нь асуувал зохино.

### **Трансвестит**

Өөр хүйсийн хүмүүс ихэвчлэн хэрэглэдэг зүйлсийг (хувцас, гоёл чимэглэл г.м) хааяа өмсөж, хэрэглэх хүсэлтэй хүмүүс. Трансвестит хүмүүс төрөлхийн хүйсээ өөрчлөх хүсэлгүй байдаг ба хүйсийн тавгүйцэлгүй байдаг. Трансжендэр хүмүүсийн тухай бичихдээ трансвестит хэмээх үгийг хэрэглэх ёсгүйг анхаарна уу. Трансвестит байдал нь хүйсийн илэрхийллийн зөвхөн нэг хэлбэр мөн ч бэлгийн чиг баримжааг ямарваа байдлаар илтгэдэггүй.

### **Хүйсийн баримжааны эмгэг (Gender identity disorder)**

Трансжендэр болон бусад өөрийн хүйсээ төрөхөд тэмдэглэгдсэн хүйсээсээ өөрөөр тодорхойлдог хүмүүст өгдөг анагаах ухааны асуудал бүхий онош. Хүмүүсийг “эмгэгтэй”, “өвчтэй” хэмээн ангилж байгаагаараа энэхүү онош нь доромжилсон өнгө аяс агуулдаг. Энэ оношийг ихэвчлэн төрөхөд тэмдэглэгдсэн хүйсийнхээ хэм хэмжээгээр хувцасладаггүй, тоглодоггүй, биеэ авч явдаггүй хүүхдүүдэд өгдөг. Ийм хүүхдүүдэд ихэвчлэн сэтгэцийн эмчилгээ, биеэ авч явах байдлыг нь өөрчлөх эмчилгээ хийж, сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх нь

цөөнгүй байдаг. Хүйсийн баримжаа илэрхийлэл нь дангаараа ямар нэгэн өвчин эмгэг биш ба энэхүү оношийг АНУ-ын сэтгэцийн эмгэгийн жагсаалт, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын өвчин ба оношийн жагсаалтаас хасуулах талаар хөдөлгөөн олон жил өрнөсний эцэст 2018 оны 6-р сарын 18-нд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Олон улсын өвчний 11-р ангилал албан ёсоор батлагдсаныг, транс байдал сэтгэцийн өвчний жагсаалтаас албан ёсоор хасагдсаныг НҮБ-ын түвшинд зарласан юм.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## БУСАД НЭР ТОМЬЁОНУУД

Трансжендэр хүмүүсийн асуудлын тухай эсвэл ярилцлаган дээр эдгээр нэр томьёонуудтай таарж болзошгүй юм. Учир нь ЛГБТИК олон нийтээс гадуурх хүрээнд тийм ч их ашиглагддаггүй ч ашиглах тохиолдолд тайлбарлах хэрэг гардаг.

### **Сизжендэр**

Транс хүй олонд харьяалагддаггүй, өөрийгөө транс гэж тодорхойлдоггүй хүмүүс. “Сиз” гэдэг латин утгвар нь “ижил, нэг талд” гэсэн утгатай бөгөөд “транс” гэдэг нь антоним буюу эсрэг үг нь юм.

### **Хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүс**

Хүйсийн хэвшмэл байдалд үл багтах гэдэг нь хүний хүйсийн баримжаа, дүр, хүйсийн илэрхийлэл нь тодорхой хүйсийн хүмүүст байх ёстой хэмээн үзэгддэг соёлын хэм хэмжээнээс өөр байхыг хэлнэ (Institute of Medicine, 2011). (ж.нь эршүүд болон эмэгтэйлэг гэх тогтсон хэм хэмжээ) Эдгээр хүмүүс нь бүгд трансжендэр хүмүүс эсвэл бүх трансжендэр хүмүүс хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүс байдаггүйг анхаарна уу. Ихэнх хүмүүсийн хүйсийн илэрхийлэл нь уламжлалд эсвэл соёлын хэм хэмжээнд бүрэн нийцсэн байдаггүй. Тиймээс хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүсийг шууд трансжендэр хүн гэж ойлгож болохгүй. Энэ нэр томьёо нь трансжендэр эсвэл транссексуал нэр томьёотой ижил утгатай биш. Аливаа хүн өөрийгөө хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүн гэж тодорхойлсон тохиолдолд энэ нэр томьёог ашиглах нь зүйтэй.

### **Нонбайнари, жендэркүйр**

Өөрийгөө эрэгтэй, эмэгтэй аль ч хүйст багтааж үздэггүй, эсвэл аль аль хүйст хамааруулж мэдэрдэг хүмүүсийн хувьд хэрэглэдэг олон улсын нэр томьёо. Энэ нэр томьёо нь трансжендэр эсвэл трансексуал үгнүүдтэй нэг утгатай үг биш. Өөрийгөө энэ нэр томьёогоор тодорхойлдог хүмүүст хэрэглэнэ.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

### **Трансжендэр хүний өөрийнх нь сонгосон нэрийг заавал ашиглах.**

Транс хүмүүс хууль ёсны нэрээ хуулийн дагуу өөрчлөх боломжтой байдаг ч бүх транс хүмүүс хууль ёсны нэрээ өөрчлөөгүй эсвэл өөрчилж амжаагүй байдаг. Гэсэн хэдий ч тэдэнд өөрсдийн сонгосон нэрээрээ дуудуулж хүндлэгдэх эрх бий. (бусад хүмүүс эсвэл алдартай хүмүүс нэр хоч, өөрсдийн сонгосон нэрээрээ дуудуулж, алдаршдагтай адил)

### **Тэдний тухай бичихдээ сонгосон нэрийг нь хашилтанд авч болохгүйг анхаарна уу.**

Хүйсээр ялгасан төлөөний үгтэй гадаад хэлээр (англи, орос, герман г.м) ярих, бичих тохиолдолд тухайн трансжендэр хүний эрхэмлэдэг төлөөний үгийг ашиглах нь зүйтэй. Зарим нонбайнари, жендэркүйр хүмүүс they, ze гэх мэт хүйсийн хувьд тодорхойгүй төлөөний үг ашиглахыг эрхэмлэдэг. Хэрвээ та ямар төлөөний үг ашиглахаа мэдэхгүй эсвэл эргэлзвэл санаа зоволгүй өөрөөс нь асуугаарай.

### **Трансжендэр, транссексуал хүмүүсийн хүйсийн талаар бичих тохиолдолд тухайн хүний хүйсийн баримжаатай нийцэх хүйсээр бичнэ үү.**

Жишээ нь: төрөхөд тэмдэглэгдсэн хүйс нь эмэгтэй ч хүйсийн баримжааны хувьд эрэгтэй хүн байвал трансжендэр эрэгтэй гэж бичнэ. Гэвч аливаа хүн өөр нэр томьёо ашиглахыг эрхэмлэдэг бол тайлбартай нь хамт тухайн нэр томьёог ашиглаарай.



<p><b>ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ</b></p>	<p><b>ХЭРЭГЛЭХЭД ЗОХИМЖТОЙ</b></p>
<p><b>“трансжендэрүүд”</b> Трансжендэр гэдгийг нэр үгээр бус, тэмдэг нэрээр хэрэглэх ёстой. “Тони бол трансжендэр” эсвэл “Жагсаалд олон трансжендэрүүд оролцлоо” гэж хэлж болохгүй.</p>	<p><b>“трансжендэр хүн”, “трансжендэр хүмүүс”</b> Жишээ нь “Тони бол трансжендэр хүн”, “Жагсаалд олон трансжендэр хүн оролцлоо” хэмээвэл зохино.</p>
<p><b>“хүйс солиулах”, “мэс заслын өмнөх”, “мэс заслын дараах”</b> “Хүйс солиулах мэс засал”, “мэс заслын өмнөх”, “мэс заслын дараах” гэх мэт үгийг хэрэглэх нь хүйсийн шилжилт хийхийн тулд хүн зайлшгүй мэс засал хийлгэх шаардлагатай гэсэн төөрөгдөл үүсэхэд хүргэдэг. Трансжендэр хүмүүсийн тухай, хүйсийн шилжилтийн тухай ярьж бичихдээ мэс заслыг хэт дөвийлгөхгүй байх нь зүйтэй.</p>	<p><b>“шилжилт”</b></p>



## **НЭР ТӨРД ХАЛДСАН, ГУТААН ДОРМЖИЛСОН ҮГ ХЭЛЛЭГ**

**Дүр эсгэх, жүжиглэх:** хүйсийн баримжаа нь хувь хүний мөн чанарын салшгүй нэг хэсэг байдаг. Трансжендэр хүмүүсийг “дүр эсгэсэн”, “эмэгтэй эсвэл эрэгтэй болж жүжиглэсэн” хэмээн ярьж бичих ёсгүй, учир нь энэ нь трансжендэр хүмүүсийн нэр төрд халдсан, тэднийг гутаан доромжилсонд тооцогддог.

**“Юм” , эр эм нь мэдэгдэхгүй “юм”:** трансжендэр хүмүүсийн мөн чанарыг нь үгүйсгэсэн утгатай тул эдгээр үгийг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.

**Манин, саармаг, хооцгон:** өмнө хэлсэнчлэн манин гэдэг нь олон улсын нэр томъёогоор интерсекс байдал. Ийм биологийн шинж тэмдэгтэй хүмүүсийг манин, эсвэл хооцгон (хуучирсан үг) гэх нь дорожлолын өнгө аястай тул хэрэглэхээс зайлсхийх ёстой. Энэ байдал нь трансжендэр байдалтай огтхон ч хамаагүй. Энэ үгийг трансжендэр хүмүүс дээр ашиглах ёсгүй.

**“Биологийн хүйс”, “генийн хүйс”, “биологийн хувьд эрэгтэй эсвэл эмэгтэй”, “генийн хувьд эрэгтэй эсвэл эмэгтэй”, “төрөхдөө эрэгтэй байсан”, “ төрөхдөө эмэгтэй байсан”, “төрөлхийн хүйс”, “төрөлхийн эмэгтэй/эрэгтэй”**

Эдгээр үгс нь эмзэг асуудлын талаар буруу ойлголт өгөх магадлал өндөртэй. Дээр дурдсанчлан хүний хүйс нь маш олон зүйлсээр (зөвхөн бэлэг эрхтэн биш) тодорхойлогддог бөгөөд биологийн бие махбод хүний хүйсийн баримжаатай хамааралгүй. Эцэст нь хүнийг бүхэлд нь тодорхойлох зүйл бол хүйс биш бөгөөд бид хүнийг хүн утгаар нь хүлээж авах хэрэгтэй.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

Ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль болон ЛГБТИК хүй олонд ээлтэй журам тогтоомжууд дүүрэг, муж, хот, улсын түвшинд хэрэгжих учиртай. Эдгээр хууль тогтоомж нь тухайн хүнийг арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, хөгжлийн бэрхшээл, наснаас эхлээд бусад олон төрлийн онцлог шинжүүдээс үүдсэн ялгаварлан гадуурхалтад өртөхөөс хамгаалахад чиглэдэг.

Монгол Улсын Засгийн газар ЛГБТИ хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулж тэдний эрхийг ханган хамгаалах ёстой талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон Гэрээдийн хороодоос өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхээр хүлээн авсан байдаг. Энэ нь МУ-ын Засгийн газар ЛГБТИ хүний эрхийг ханган хамгаалах үүргээ Олон улсын өмнө хүлээн зөвшөөрсөн гэсэн үг юм. Хууль, эрх зүйн хувьд 2017 оны 7-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулиар Ялгаварлан гадуурхахыг гэмт хэрэг болгон зүйлчилсэн.

АНУ-ын хувьд мужийн болон орон нутгийн ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулиуд бүгд хүйсийн баримжаа (трансжендэр хүмүүсийг хамгаалах), бэлгийн чиг баримжаанд (ЛГБ хүмүүсийг хамгаалах) үндэслэсэн ялгаварлан гадуурхалтын эсрэг заалтыг тусгасан уу гэвэл үгүй юм. ЛГБТИК хүмүүсийг ялгаварлан гадуурхалтаас ягштал хамгаалсан үндэсний хэмжээний хууль алга байна.

Одоогоор ердөө 18 муж ЛГБТИК хүмүүсийг ажил хөдөлмөрийн орчин, байр сууц, олон нийтийн газрууд дахь ялгаварлан гадуурхалтаас хамгаалсан хуулийг баталжээ. Үүнээс гадна хоёр муж (Нью-Хэмпшир, Висконсин) иргэдээ бэлгийн чиг баримжаанд үндэслэсэн хамгаалалтаар хангадаг боловч хүйсийн баримжааг тусгадаггүй. Харин Юта мужийн хувьд трансжендэр хүмүүсийг ажлын байр болон амьдрах сууцан дахь ялгаварлан гадуурхалтын эсрэг хамгаалдаг боловч олон нийтийн газруудад үйлчилдэггүй.

Гэсэн ч эдгээр хууль тогтоомжууд Америк дахь ЛГБТИК хүн амын зөвхөн 48 хувийг хамардаг нь хүй олны

дийлэнх хэсгийг хууль ёсны ялгаварлан гадуурхалтад өртөх нөхцөлийг бүрдүүлж байна. 2015 оны судалгаанаас үзэхэд, ЛГБТ хүмүүсийн 63 хувь нь ямар нэгэн байдлаар гадуурхалтад өртөж байсан гэж мэдээлжээ. Үүнээс 47 хувь нь ажлын байран дахь гадуурхалтад өртсөн бол 19 хувь нь олон нийтийн газар нэвтрэх гэж байгаад нэрвэгджээ. 14 хувь нь амьдарч буй байр сууцандаа гадуурхагдсан бол үлдсэн есөн хувь нь боловсролын тогтолцооны орчинд ялгаварлан гадуурхалтад өртсөн тухайгаа мэдэгджээ.

Дэлхий дээр 2019 оны байдлаар 70 улс гэмт хэрэг хэмээн тооцдог бол үлдсэн улс орнууд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомжтой. Үүнд, Европ бүхэлдээ, мөн Латин Америкийн ихэнх орон, Төв ба Хойд Америкийн ихэнх орон болон Африкийн хэд хэдэн орон багтаж байна. Харин Аргентин, Бельги, Бразил, Канад, Дани, Грийнланд, Финлянд, Франц, Исланд, Ирланд,

Люксембург, Мексик, Голланд, Шинэ Зеланд, Норвеги, Португал, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Их Британи, АНУ, Уругвай, Тайвань зэрэг Дэлхий даяар 26 улсад ижил хүйсийн гэрлэлт нь хууль ёсных бол бол Андорра, Австрали, Австри, Чиле, Колумб, Хорват, Чех, Эквадор, Эстони, Герман, Унгар, Итали, Япон, Лихтенштэйн, Мальта, Швейцарь, Венесуэл улсуудад ижил хүйсийн гэрлэлттэй тэнцэх иргэний гэрлэлтийн зохицуулалт байна. Харамсалтай нь ижил хүйсийн харилцан зөвшилцлийн үндсэн дээр хийгдсэн бэлгийн зан үйлийг Иран, Судан, Саудын Араб, Мавритани, Сомалид болон Нигерийн зарим хэсэгт цаазаар авах ялаар ялласаар байна.

### **Трансжендэр хүмүүсийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалахын чухал тал**

Трансжендэр хүн амын цочирдмоор их хувь ялгаварлан гадуурхалтын аль нэг хэлбэртэй таарч байжээ. 2011 онд явуулсан Трансжендэр ялгаварлан гадуурхалтын үндэсний судалгаанд дурдсанаар, оролцогчдын 63 хувь нь ноцтой ялгаварлан гадуурхалттай нүүр тулсан бол 23 хувь нь маш ноцтой буюу амьдрал сүйтгэх шинжтэй үйл явдал, хүчирхийлэлд гурав ба түүнээс дээш удаа өртсөнөөр тодорхойлогддог (жишээлбэл, эмнэлгийн тусламж үйлчилгээн хүртэж чадахгүй байх, бэлгийн дарамтанд өртөх, өмч, эд хөрөнгөө хураалгах, багш нарын дарамт шахалт гэх мэт) “гамшгийн хэмжээний ялгаварлан гадуурхалт”-тай учирч байжээ.

Түүнчлэн трансжендэр хүмүүс бүхий л төрлийн арьс өнгө, шашин шүтлэг, нас

хүйс, ур чадвар, бэлгийн чиг баримжаа болон улс үндэстнийг төлөөлдөг учраас тухайн трансжендэр хүний хувийн шинж чанаруудын огтлолоос хамаарч тулгардаг ялгаварлан гадуурхалт нь харилцан адилгүй байх магадлалтай. Тухайлбал, өнгөт арьстан трансжендэр хүмүүсийн ядуурал, хүчирхийлэлд өртсөн, эрх чөлөөгөө хасуулсан тохиолдол трансжендэр хүй олон доторх бусад хүмүүстэй харьцуулахад хамаагүй өндөр байна.

### **“Ариун цэврийн өрөөний хууль” хэмээх домог**

ЛГБТИК хүмүүст чиглэсэн гадуурхалтын хамгаалалтууд голдуу хөдөлмөр эрхлэлт, байр сууц, олон нийтийн газруудыг хамардаг бол үүнийг эсэргүүцэгчид ариун цэврийн өрөөний тухай айдас зохиомлоор үүсгэж, энэ хуулийг баталснаар бэлгийн гаж донтонгууд эмэгтэйчүүдийн ариун цэврийн өрөөнд нэвтрэх эрхтэй болно гэж мэтгэдэг. Заримдаа тэд трансжендэр эмэгтэйчүүдийг эмэгтэй хүмүүс биш учраас эмэгтэйчүүдтэй нэг ариун цэврийн өрөө ашиглах ёсгүй гэж сүржигнэдэг. (Бас трансжендэр эмэгтэйчүүдийг зохисгүй авиргай, түрэмгий гэсэн далд утга шингээх нь их.) Гэвч трансжендэр хүмүүс өдөр бүр амьдардаг тэр л хүйсийн баримжаанд нь нийцсэн ариун цэврийн өрөөнд байхдаа бусдыг аюулд оруулдаг гэх энэ ойлголтыг батлах баримт нотолгоо огт байхгүй юм.

Энгийнээр хэлэхэд, энэ мэт мэдэгдлүүд бүхэлдээ худал. Трансжендер хүмүүсийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах нь бусдыг доромжлох, гэмтээх зорилгоор ариун цэврийн өрөөнд орох болон хүний хувийн орон зайд халдах нь

хууль бус гэдгийг тусгаж өгсөн урт хугацаанд оршиж буй хуулийг өөрчлөнө гэсэн үг биш. Зарим мужийн ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулиудад зүй бус зорилгыг өөгшүүлэхгүй байх үүднээс хүйсийн илэрхийллийг зарлахгүй гэдгээ ил шулуунаар мэдэгдсэн нь бий. Цагдаа нар хүмүүсийг аюулгүй байлгаж, баривчлагаа явуулж, халдагч этгээдүүдэд хариуцлага тооцохдоо одоогийн олон нийтийн байдлын тухай хуулийг ашигладаг. Тэгэхээр трансжендэр хүмүүсийн аюулгүй байдлыг хангах заалтыг эдгээр хуулинд нэмснээр олон нийтийн аюулгүй байдалд заналхийлэл үүснэ гэж ахин дахин мэтгэдэг эсэргүүцэгчдийн үг үндсэндээ худал юм.

Хэрвээ сэтгүүлчид ЛГБТИК хүмүүсийг хамруулсан ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулиудыг гагц “ариун цэврийн өрөөний хууль” гэх нэрийн дор төвлөрүүлж, эсвээс өргөн цар хүрээтэй бодлогыг ариун цэврийн өрөөний тухай жижигхэн асуудал болгон хумих явдлаа давтсаар байвал үзэн ядалт, халдлага, шударга бус хандлага зэргээс хүмүүсийг хамгаалдаг эдгээр хуулийн талаарх олон нийтийн ойлголтыг сулруулна. Хэдийгээр эдгээр хуулиуд трансжендэр хүмүүст өдөр бүр амьдардаг тэр хүйстэйгээ нийцэх ариун цэврийн өрөөг ашиглах эрхтэй болгож буй ч ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулиуд нь ажил хөдөлмөр эрхлэх, байр сууцандаа аюулгүй амьдрах, боловсрол олж авах, тангарагтны үйлчилгээнд оролцох, зээл авах гэх мэтчилэн үүнээс хамаагүй илүү өргөн цар хүрээг хамардаг билээ.

Үүн дээр нэмэхэд, трансжендэр эмэгтэйчүүдийг гутаан доромжлох, нэр төрийг сэвтээх аливаа оролдогыг хүчтэй эсэргүүцэх хэрэгтэй. Гей

эрэгтэйчүүдийн тухай хуучны, маш муухай хэвшмэл ойлголтуудын (жишээ нь, хүүхэдтэй хурьцах донтой гэх мэт) ор үндэсгүйг гүйцэт илчлэн харуулсан шиг трансжендэр эмэгтэйчүүдийн тухай адил төстэй ойлголтуудын алдааг залруулах ёстой. Америкийн сэтгэцийн эмгэг судлалын төв, Америкийн сэтгэл судлалын нийгэмлэг болон бусад эрүүл мэндийн байгууллагууд жигшмээр муухай тэрхүү хэвшмэл ойлголтуудыг няцааж, буруу болохыг тогтоосон юм. Сэтгүүлчид трансжендэр хүмүүсийн эсрэг тэмцэгчдээс үндэслэл шалтгаанаа баталгаажуулан нотлохыг шаардаж, ингэхдээ тэдний хүн чанарыг алдагдуулахад чиглэсэн гүтгэн доромжилсон шинжтэй хэвшмэл буруу ойлголтоос тэс өөр амьдралыг туулсан трансжендэр хүмүүсийн дуу хоолойг оруулах хэрэгтэй.

Бодит амьдрал дээр бүх хүн, трансжендэр хүмүүс ч тэр, нийтийн ариун цэврийн өрөөн дэх хувийн орон зай, аюулгүй байдлын талаар санаа зовнидог. Харамсалтай нь, трансжендэр хүмүүс нийтийн ариун цэврийн өрөөг ашиглах гэж оролдох үедээ хэл амаар доромжлуулж, бие махбодийн халдлагад өртөх явдал түгээмэл гардгийг хэд хэдэн судалгаа харуулж буй. Цаашилбал, эсэргүүцэгчдийн ариун цэврийн өрөөний тухай хуурамч мэдэгдлүүдэд хэт ач холбогдол өгөх нь трансжендэр хүмүүсийн тулгардаг бусад шударга бус явдлуудаас олны анхаарлыг сарниулж байна. Тухайлбал, трансжендэр хүмүүс ердөө хэн бэ гэдгээсээ болж ажлаасаа халагдаж, амьдрах газар олж чадахгүй байгаа нь эсрэг талыхны ариун цэврийн өрөөний хуурамч мэдэгдлүүдийн тухай мэдээ нийтлэлүүдийн сүүдэрт дарагдах буюу огт мэдээлэгдэхгүй өнгөрдөг.

Ижил хүйсийн хосуудын гэрлэлтийг сурвалжлах, мэдээлэхэд гэрлэлтийн тэгш эрх болон эсвэл ижил хүйсийн хосуудын гэрлэлт зэрэг нэр томъёог ашиглавал тохиромжтой. “Гей гэрлэлт”, “ижил хүйстний гэрлэлт” зэрэг нэр томъёо нь ижил хүйсийн хүмүүсийн гэрлэлтийг бусад гэрлэлтээс аль нэг талаараа өөр гэдэг санааг илтгэж мэдэх учраас ашиглахгүй байх нь зүй.

Монгол улсын хувьд ижил хүйсийн хосуудын гэрлэх болон хүүхэд өргөж авах хуулийн зохицуулалт байхгүй. Хүүхэдтэй ижил хүйсийн хосууд нийгэмд ил харагддаггүй учраас байдаггүй гэж ойлгож болохгүй.

АНУ-ын хувьд 2015 оны зургадугаар сард Дээд шүүх нь “Обергефелл ба Хожез”-ын хэрэг дээр америк хүн бүр хайртай хүнтэйгээ гэрлэх хууль ёсоор эрхтэй хэмээн тогтоосон билээ.

### **Уильямс институтийн 2015 оны арваннэгдүгээр сард гаргасан тайланд дурдсанаар,**

Нэгдсэн Улсад 486 мянган гэрлэсэн ижил хүйсийн хос байна. Тус институт Америкийн хүй олны 2013 оны судалгааны тоо баримтыг ашиглан 122 мянга орчим ижил хүйсийн хос 18-аас доош насны хүүхдүүд өсгөж буйг тооцоолсон бөгөөд ижил хүйсийн хосууд бусад хосуудаас илүү хүүхэд өргөж авах, асрамжийн хүүхэдтэй болох магадлалтай байдаг аж.

### **Уильямс институтийн 2013 онд гаргасан “АНУ дахь ЛГБТ эцэг эхчүүд” тайланд дурдсанаар,**

лесбиян, гей, бисексуал, эсвэл трансжендэр эцэг эхтэй зургаан сая гаруй америк хүүхэд (хүүхэд болон насанд хүрэгчид) байна. Ижил хүйсийн хосууд, тэдний хүүхдүүд нь арьс өнгө болон үндэстний цөөнхийн төлөөлөл байх магадлал их. 18-аас доош насны хүүхэдтэй ижил хүйсийн хосуудын 39 хувь, хүүхдүүдийнх нь тал хувь цагаан арьстан биш байна.

Миссисипи (26%), Ваёмин (25%), Аляска(23%), Айдахо (22%), Монтана (22%) муж төрсөн, өргөмөл, дагавар хүүхдүүдээ өсгөж буй ижил хүйсийн хосуудын тоогоор хамгийн өндөр хувьтайд орно.

### **2015 оны Обергефеллийн шийдвэрийн дараагаар ижил хүйсийн хосуудад хүүхэд өргөж авах боломж илүү нээлттэй болжээ.**

Өдгөө бүх 50 муж гэрлэсэн ижил хүйсийн хосууд хамтран болон хоёр дахь эцэг, эх болох замаар хүүхэд үрчлэхийг хуульчилжээ. Гэсэн хэдий ч зарим мужийн хууль тогтоох байгууллагууд хүүхэд үрчлүүлэх зуучлалын товчоодод зарчмын болон шашны эсэргүүцлээс үүдэлтэйгээр ижил хүйсийн хосуудтай ажиллахаас татгалзах эрх олгох хуулийн төсөл санаачилж байна.

Гэрлэлтээ батлуулаагүй ижил хүйсийн хос болон ЛГБТИК ганц бие эцэг эх хүүхэд өргөж авах, асрамжийн эцэг эх болох тухай хуулиуд харилцан адилгүй.



## **Хүүхэдтэй болох, хүүхэд өргөж авах тал дээр хийсэн судалгаа**

Ижил хүйсийн хосуудын өсгөсөн хүүхдүүдийн дунд явуулсан судалгааны тухай хэлэлцүүлэг ихэнхдээ ижил хүйсийн эцэг эхчүүдийг эсэргүүцэгчид болон тэдгээр гэр бүлийн хуулийн хамгаалалтын дунд улс төрийн шинжтэй ширүүн маргаан дэгдээж орхидог. Ижил хүйсийн хосуудын эцэг эх болох явдлыг эсэргүүцдэг хүмүүс ерөнхий хоёр үндэслэлээр өөрсдийгөө зөвтгөдөг: нэгдүгээрт, гэрлэсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүлд өссөн хүүхдүүд маш сайн өсөж хүмүүждэгийг нийгмийн ухааны “бүх” судалгаа харуулдаг, хоёрдугаарт, үүнээс зөрсөн, эсрэг үр дүнтэй бусад аль ч судалгаа алдаа мадагтай.

Гэвч үнэндээ, ижил хүйсийн хосуудын өсгөсөн хүүхдүүдийн байдал хийгээд тухайн гэр бүлийн бүтэц дээр чиглэсэн судлаачдын бичвэрүүд олон байдгийн дээр улам өсөн нэмэгдэх хандлагатай. Ижил хүйсийн хосууд хүүхэд өсгөж хүмүүжүүлснээс үүдэх сөрөг нөлөө үгүйг уг судалгаанууд батлан харуулсаар байна.

### **Үүнээс гадна хүүхэд асран хамгаалах чиглэлийн хамгийн найдвартай, бүрэн итгэж болохуйц бараг бүх мэргэжилтэн**

(Америкийн Хүүхдийн халамж үйлчилгээний нэгдэл, Эван Б.Доналдсоны үрчлэлийн институт, Америкийн Хүүхдийн эмнэл зүйн академи зэрэг үүнд орно) **халамж хайраар дүүрэн, зөв, сайн эцэг эсвэл эх байхад тухайн хүний бэлгийн чиг баримжаа**

**огтхон ч хамаагүйг хэдийн тогтоосон билээ.**

**Ижил хүйсийн асран хамгаалагчдыг эсэргүүцдэг хүмүүсийн хийсэн ихэнх судалгаанд нэг том алдаа бий: тэд ижил хүйсийн асран хамгаалагчтай гэр бүлүүдийг судалдаггүй.**

Үүний оронд ганц бие эцэг эхтэй амьдарч буй хүүхэд, гэрлэсэн эцэг эхтэй амьдарч буй хүүхдийн хооронд ерөнхий харьцуулалт хийдэг. Тиймээс энэ мэт судалгааг ашиглан эцэг эхийн бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа нь хүүхдийн сайн сайханд нөлөөлдөг гэж үзэх нь зохисгүй юм.

2012 онд Марк Регнерус болон хуучинсаг үзэлтэй Уизерспун институт хамтран явуулсан судалгаагаараа ижил хүйсийн эцэг эхийн өсгөсөн хүмүүс эсрэг хүйсийн эцэг эхтэй өссөн хүүхдүүдтэй харьцуулахад сөрөг явдлуудтай илүү их тулгардаг гэж зарласан нь бий. Гэвч Регнерусын судалгаа арга барилын хувьд алдаатай, хэт нэг талыг баримталсан нь тэр даруй ил болсон билээ. Тэд судалгаандаа эсрэг хүйсийн эцэг эхтэй тогтвортой гэр бүлд өссөн хүүхдүүдийг, ерөнхийдөө ганц бие, ганц хоёр удаа ижил хүйсийн хүндээ татагдаж байсан асран хамгаалагчтай хүүхдүүдтэй харьцуулсан байдаг. Судалгаанд оролцогчдоос зөвхөн хоёр хүн төрсөн цагаасаа ижил хүйсийн гэр бүлд өссөн байв. Америкийн Социологийн нийгэмлэг энэ судалгааг хянасныхаа дараа уг судалгаанд “Ижил хүйсийн асран хамгаалагчид муу эцэг эхчүүд, тэдний хүүхдүүд сөрөг мууг туулдаг гэх дүгнэлтэд хүрэх үндэслэл огт алга” гэж зарласан юм.



Хэдий ийм ч ЛГБТИК хүй олныг эсэргүүцэгчид Регнерусын судалгааг өнөөг хүртэл хэрэглэсээр байна. Аз болоход ихэнх хэвлэл мэдээллийн сувгууд Регнерусын судалгааны цаадах алдаа дутагдал, давхар санааг олж нээхдээ сонор сэрэмжтэй ажилласан байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд иймэрхүү алдаа мадагтай судалгаануудыг зохих байранд нь тавьж, ижил хүйсийн гэр бүлүүд хүүхэд өсгөж хүмүүжүүлэхдээ сөрөг нөлөө үзүүлдэггүйг харуулсан үнэн зөв судалгаануудын ач холбогдлыг таниулахад чухал байр суурьтай билээ.

**Яг үүнтэй адилаар, уг судалгаанууд ижил хүйсийн асран хамгаалагч, эцэг эхтэй хүүхдүүд, эсрэг хүйстэй эцэг эхтэй хүүхдүүдтэй “яг адилхан” биш байгааг харуулж буйг тусгах нь бас чухал юм.**

Ялгаатай талууд чухамхүү бий (жишээ нь, нэгэн судалгаанд лесбиян хоёр ээжтэй охид том болсон хойноо эмэгтэйчүүдийн төдийлэн сонгодоггүй мэргэжлийг эзэмших нь элбэг байдгийг олж тогтоосон). Гагцхүү иймэрхүү ялгаа хүүхдүүдэд уршигтай эсэх нь энэхүү сэдвийн хүрээн дэх жинхэнэ хамааралтай асуулт мөн билээ; харин үгүй гэдгийг олж тогтоосон хангалттай олон судалгаа бий.

**Заримдаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ижил хүйсийн гэр бүлүүдийн тухай хэлэлцүүлгийг явуулахдаа санаандгүйгээр хуурамч дихотомия үүсгэж, эсрэг хүйсийн гэр бүлүүдийг ижил хүйсийн гэр бүлүүдийн эсрэг**

**сөргүүлэн тавьж орхидог.**

Сайн аав ээж байх чадваруудыг эзэмшсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс гей, стрэйт, бисексуал, трансжендэр гээд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллийн бүхий л төрлийн төлөөллөөс гарч ирдгийг судалгаа харуулдаг. Эрдэмтэд хийгээд эмч нар хүртэл хүний бэлгийн болон хүйсийн баримжаа нь сайн эцэг эх байхтай холбоотой гол хүчин зүйл биш гэдэгтэй санал нэгддэг.

**Трансжендэр эцэг эхчүүдэд тулгардаг асуудал бэрхшээл онцгой содон.**

Гэрлэснийхээ дараа хүйсийн шилжилтэнд орсон хүмүүсийн эхнэр/нөхөр өөрчлөлтийг нь хүүхэд асран халамжлах тал дээр асуудал гэж үзвэл, тэд хүүхдээ алдах аюултай учирдаг. Ламбда хуулийн дагуу “Шүүх ерөнхийдөө хүүхдийг асран халамжлах, хүүхэдтэйгээ уулзах захирамж гаргахдаа хүүхдийн ашиг сонирхолд хамгийн сайнаар, шууд утгаар нөлөөлөх хүчин зүйлсийн дагуу шийдвэр гаргах эрхтэй” гэжээ. Хэрэв трансжендэр эцэг эхийн хүйсийн баримжаа, илэрхийлэл нь хүүхдэдээ ямар нэгэн байдлаар муугаар нөлөөлөхгүй гэж үзвэл, асран халамжлах болон хүүхэдтэйгээ уулзах эрхийг уг шалтгаанаар өөрчлөх ёсгүй хэмээн үздэг. Гэсэн хэдий ч зарим шүүх эцэг эх нь трансжендэр учраас хүүхдэдээ “нийгмийн хор хохирол” учруулна хэмээн шударга бус тогтоомж гаргасан байдаг.

**ГЛААД-ын зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ЛГБТИК гэр бүлүүдийг оршихуйг нь няцаасан хүмүүсээс өөрсдийгөө хамгаалж буй байдлаар**

**биш, харин хувийн түүхээ өөрсдийн хэл, арга замаар өгүүлэхэд нь дэм болохыг уриалдаг.**

### **Хэллэг ба нэршил**

ЛГБТИК гэр бүлүүдийн тухай сурвалжлахдаа мэдээ баримт цуглуулах шатандаа ч, тэдний түүхийг өгүүлэх хэл найруулга дээр ажиллахдаа ч эрхэм чанарыг нь эрхэмлэж, хүндэтгэлтэй хандах нь чухал.

ЛГБТИК эцэг, эх, асран хамгаалагчтай гэр бүлүүдийг дүрслэхдээ гэр бүл, эцэг эх, ээжүүд, аавууд, асран хамгаалагч гэх мэт үгс дээр хашилтын тэмдэг хэзээ ч бүү хэрэглээрэй. Иймэрхүү арга барилыг ихэвчлэн ЛГБТИК хүмүүсийг эсэргүүцэгч бүлгэмүүд хайр халамжаар дүүрэн тэрхүү гэр бүлүүдийг үгүйсгэх, эрхэм чанарыг нь алдуулах, буруушаахдаа хэрэглэдэг юм.

Хүүхэд асран хамгаалах чиглэлийн хамгийн найдвартай, бүрэн итгэж болохуйц бараг бүх мэргэжилтэн халамж хайраар дүүрэн, зөв, сайн эцэг эх байхад тухайн хүний бэлгийн чиг баримжаа огтхон ч хамаагүйг хэдийн тогтоосон билээ.



Сүсэг бишрэлтэй хүмүүс ЛГБТИК хүмүүс болон тэдний эрхийг эсэргүүцдэг гэсэн нийтлэг домог бий. ЛГБТИК эрхийн эсрэг үзэлтнүүд энэхүү домгийг ЛГБТИК хүмүүс болон тэдний гэр бүлийн эсрэг дайралттайгаа сүлж, Христийн шашнаар халхавч хийсэн нь хэвлэл мэдээллийн нийтлэл нэвтрүүлгүүдэд тусагдах ЛГБТИК тэгш эрхийг “Бурхан ба гей хүмүүс” гэсэн эсрэгцэлд хүссэн хүсээгүй хөтөлдөг. Хэдийгээр шашны хүрээнд ЛГБТИК хүмүүсийг хүлээн зөвшөөрөх явдал нэмэгдэж буй боловч шашны дөрвөн тэргүүний гурав нь ЛГБТИК хүний тэгш эрхийн асуудлаар мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөхдөө үүнийг эсэргүүцэх шашны уламжлал хийгээд тодорхой бодлого бий гэсэн юм.

**ЛГБТИК хүмүүсийн тэгш эрхийг дэмжиж буй шашны гол урсгалууд.** Unitarian Universalist Association, United Church of Christ, Metropolitan Community Church зэрэг сүмүүд хэдэн арван жилийн турш ЛГБТИК хүмүүсийг хамруулах бодлоготой байсаар ирсэн билээ. Үүнд, ЛГБТИК хүмүүст сахил хүртээх, ижил хүйсийн гэрлэлтийг сүмдээ адислах болон хуулийн хүрээнд ЛГБТИК хүний эрхийг өмгөөлөх, дэмжих зэрэг багтана. Харин The Episcopal Church, Conservative Judaism, the Evangelical Lutheran Church in America, and the Presbyterian Church (USA) сүмүүд сүүлийн 20 жилийн дотоо ЛГБТИК хүмүүсийг багтаах бодлоготой болжээ. Эдгээр сүмийн тэргүүнүүд ихэвчлэн гэрлэх эрх, ажил хөдөлмөрийн орчинд ялгаварлан гадуурхахгүй байх, трансжендэр хүмүүсийг хамруулах болон бусад ЛГБТИК хүний эрхийн асуудлаар дуу хоолойгоо хүргэж, тэгш эрхийн дэмжигч болдог.

**Шашны бусад урсгалууд ч ЛГБТИК хүний тэгш эрх, асуудлуудын тухай хэлэлцүүлгүүдийг өдөөж байна.** Бусад урсгалууд ч дээрх сүмүүдийн адил ижил хүйсийн хосуудыг адислах, ЛГБТИК санваартанг өргөмжлөх зэргээр ЛГБТИК хүмүүсийг тэгш хамруулах үйлсийг бүрэн дэмжлэгтэйгээр үргэлжлүүлсээр байна. Тухайлбал, Нэгдсэн Методист Сүм ЛГБТИК хүнийг хамруулахаар бодлогодоо өөрчлөлт оруулаагүй боловч тус сүмийн зарим тэргүүн тэдгээр бодлогыг шинэчлэхийг уриалж, ЛГБТИК хүмүүсийн тэгш эрхийг дэмжиж буйгаа олон нийтийн өмнө илэрхийлсэн нь бий. ЛГБТИК хүй олон ямар ч шашинтай байж болно. Бүр ЛГБТИК хүмүүсийн эсрэг үзэлтнүүд дунд ч ЛГБТИК хүмүүс байх боломжтой. ЛГБТИК хэрнээ муслим, ортодокс еврей болон протестант шашинтай хүнтэй та таарч ч мэднэ. Мормоны сүм гэхэд ЛГБТИК хүмүүсийн талаарх байр сууриа өөрчлөн, “экс-гей” хэмээх гэр бүлүүдийг хөндийрүүлэхэд чиглэсэн хөтөлбөрөө зогсоожээ.

**ЛГБТИК хүмүүсийн эсрэг тэмцэгчид зөвхөн “шашны” эсвэл “Христ итгэлтнүүдийн” төлөөлөл мэтээр мэдээллийн хэрэгслээр гардаг бөгөөд сүсэг бишрэлтэй хэрнээ ЛГБТИК хүмүүсийн эрхийг дэмждэг хүмүүсийн дуу хоолой ихэвчлэн орхигддог.** Пэт Робертсон, Харри Жэксон, “Focus on the Family”, “Family Research Council”, “Traditional Values Coalition”, “Alliance Defending Freedom”, “Institute on Religion&Democracy” зэрэг ЛГБТИК хүмүүсийн эсрэг тэмцэгчид өөрсдийгөө сүсэг бишрэлтэй америкчуудын төлөөлөл гэж харуулахыг эрмэлздэг. Гэсэн атлаа тус бүлгүүдийн үзэл баримтлал төлөөлдөг гэх тэр олонхынхоо үзэл бодолтой нийцдэггүй. Ялангуяа ЛГБТИК хүмүүсийн эсрэг үг хэллэг, үйлдлүүд Ромын Католик сүмээс улбаатай ч өдгөө  $\frac{3}{4}$  нь ЛГБТИК хүмүүсийн тэгш

эрхийг дэмждэг Ромын католикуудын хувьд авч үзвэл үүн шиг үнэн зүйл гэж үгүй. Сүсэг бишрэлтэй хүмүүсийг оролцуулаад Америкийн нийт иргэдийн дийлэнх хувь нь ЛГБТИК хүмүүсийг хамруулсан тэгш эрхийн хуулиудыг дэмжих хандлагатай байна.

**ЛГБТИК хүмүүсийн эсрэг тэмцэгчид хэвлэл мэдээлэл, медиа хэрэгслийн анхааралд өртөхийн тулд тэдний нэр хүнд, тэгш эрх рүү халдах нь зөв эсэхийг бодолцоно уу.** Ялгаварлан гадуурхалтын талаар хэвлэл мэдээлэлд бичих, дурдах ёстой болвол ЛГБТИК хүний эрхийг дэмждэг сүсэг бишрэлтэй хүмүүс болон ЛГБТИК хүмүүсийг шашиндаа багтаадаг, нийгмээс ирэх халдлагыг эсэргүүцэх чадвартай дуу хоолойг хичээнгүйлэн эрж олоорой.

**Шашин болон ЛГБТИК хүмүүсийн талаар бичих тохиолдолд ЛГБТИК шашны тэргүүнүүдийн дуу хоолойг багтаана уу.** Дашрамд дурдахад, GLAAD, the Institute for Welcoming Resources, the National Black Justice Coalition, the Human Rights Campaign, the World Congress of GLBT Jews зэрэг байгууллагууд сэтгүүлчдийг баталгаатай төлөөлөгчидтэй шууд холбож өгөх боломжтой. Монгол улсад гэвэл та бүхэн ЛГБТ Төвөөс зөвлөгөө, тусламж авахад чөлөөтэй.

### **Шашин шүтэх эрх чөлөөг дахин шинэчилсэн акт (RFRA)**

Хэдийгээр АНУ-ын Үндсэн хуулийн Анхны нэмэлт өөрчлөлт нь шашин шүтэх эрхийг хангадаг ч Конгресс 1993 онд шашны цөөнхийн урсгалыг хамгаалах зорилгоор Шашин шүтэх эрх чөлөөг дахин шинэчилсэн актыг баталжээ. Үүнд зааснаар, аливаа шашин зөвхөн Засгийн газрын сонирхолд нөлөөлж, албадахыг оролдсон тохиолдолд л Засгийн газар шууд хориг тавих эрхтэй юм.

Гэсэн ч Америк даяар ижил хүйсийн гэрлэх эрхийг хуульчилсан Дээд шүүхийн “Обергефелл ба Хожес”-ын шийдвэрийн дараа олон муж RFRA-гийн мужийн хувилбаруудыг батлах оролдлого хийсэн байдаг. Ингэснээр RFRA-гийн хамгаалалтанд багтсан хүмүүс, ашгийн төлөө байгууллагууд ЛГБТИК хүй олонд бараа бүтээгдэхүүн зарах, үйлчилгээ үзүүлэхээс тагталзах эрхтэй болно. RFRA-д шинэ зүйл заалт оруулан өргөжүүлсэн болон санал оруулсан тэдгээр төслүүд нь муж, орон нутгийн бусад хуультай, тэр дундаа ялгаварлан гадуурхалтын эсрэг хуультай зөрчилдөж буй агаад хүмүүст аль хуулийг дагаж мөрдөхөө шийдэх мэдлийг өгч байгаа юм.

Сэтгүүлчид RFRA-ийн талаар судалж, цөөнхүүдэд, тэр дундаа ЛГБТИК хүмүүст хэрхэн нөлөөлдөг талаар судлах аваас тун их нэмэртэй. Хуулийн мэргэжилтнүүд энэхүү ялгаварлан гадуурхалтыг дэмжсэн тодорхойгүй үг хэллэг, ойлгомжгүй найруулгын талаар шууд ярьж болно. Мөн ЛГБТИК хүмүүстэй хийж буй бизнесийн үйл ажиллагаанд “шашин шүтэх чин итгэл” хэрхэн хөндөгдөж буй талаар сэтгүүлчид асууж байх хэрэгтэй.

Монгол улсын хувьд АНУ шиг шашин нь төрдөө шууд нөлөөлдөг биш юм. Гэвч ЛГБТ Төвийн цахим хаяг руу эсэргүүцсэн утгатай мессеж, коментууд Христийн шашинтай хүмүүсээс ирэх нь их. (Шашин шүтлэг ба ЛГБТИК хүмүүсийн талаар сонирхолтой мэдээллийг “Homo Liber” номноос унших боломжтой.)

Холбооны мөрдөх товчооны 2014 оны тайланд бэлгийн чиг баримжаанаасаа болж үзэн ядалтын гэмт хэргийн хохирогч болсон 1248 хүн (цагдаад мэдэгдсэн үзэн ядалтын гэмт хэргийн 18.6 хувь), хүйсийн баримжаанаасаа болж үзэн ядалтын гэмт хэргийн золиос болсон 109 хүн (цагдаад мэдэгдсэн үзэн ядалтын гэмт хэргийн 1.8 хувь) бүртгэгджээ. ЛГБТИК болон ХДХВ-ын халдвартай хүмүүсийг үзэн ядаж, хүчирхийлснээс үүдсэн аллагын хэргийн тоо 2015 онд 20 хувиар ихэссэн тухай Хүчирхийллийн эсрэг үндэсний эвсэл /NCAVP/ мэдээлсэн бөгөөд өнгөт арьстан, трансжендэр хүмүүс голдуу гэмт хэргийн золиос болж буйг анхааруулсан. Амиа алдсан ЛГБТИК хохирогчдын 62 хувь нь өнгөт арьстан, хүн амины хэргийн золиос болсон нийт хохирогчдын 54 хувь нь өнгөт арьстай трансжендэр эмэгтэйчүүд байсныг NCAVP мэдэгдсэн юм.

**Хүчирхийлэлд өртсөн трансжендэр хүмүүсийг дахин хохирогч болгохоос зайлсхийгээрэй.** Трансжендэр хүмүүс, ялангуяа өнгөт арьстай трансжендэр эмэгтэйчүүд үзэн ядалтаас үүдсэн гэмт хэргийн золиос болох нь түгээмэл. Харамсалтай нь эмгэнэлтэй ийм тохиолдлуудыг мэдээлэхэд хохирогчийн трансжендэр байдлыг хүндэтгэж үздэггүйгээр барахгүй заримдаа шоглох явдал гардаг. Сэтгүүлчид хүчирхийлэлд өртсөн трансжендэр хохирогчдын талаар сурвалжлахад цагдаагаас төдийгүй гэрч, түүний гэр бүл, найз нөхдөөс хүртэл бүрэн, үнэн зөв мэдээлэл ирдэггүй. GLAAD-ын зүгээс трансжендэр хохирогчдын талаар хэрхэн шударга, үнэн зөв мэдээлэх тухай тусгасан “Хоёр дахин хохирогч: Гэмт хэргийн хохирогч болсон трансжендэр хүмүүсийн тухай мэдээлэх нь” нэртэй онцгой тайланг гаргасан нь бий.

### **Хам сэдвээр хангах.**

Трансжендэр хүй олон бол дэлхий даяар хамгийн ихээр ялгаварлан гадуурхалт, алагчлалд өртдөг бүлэг юм. Хэрвээ трансжендэр хохирогч харгис хэрэг

тохиох үед хэцүү бэрх, хяслантай нөхцөлд байсан бол та энэ тухай мэдээлэхдээ уншигч, үзэгчдээ хам сэдвийн хүрэн дэх агуулгаар хангаж өгөх нь зүйтэй. [Glaad.org/transgender](http://Glaad.org/transgender) сайтаар зочилсноор трансжендэр хүмүүсийн тулгардаг ажилгүйдэл, ядуурал, ялгаварлан гадуурхалт гээд хэмжээгээ алдсан их алагчлалын талаар статистикийн бодит мэдээллийг авах боломжтой. Трансжендэр хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтын талаар нэмэлт мэдээлэл авах бол Үндэсний ЛГБТИК Ажлын хэсэг болон Трансжендэр тэгш эрхийн үндэсний төвөөс эрхлэн гаргасан “Injustice at every turn” (Алхам бүрт тохиох шударга бус явдал) тайланг үзнэ үү.

**Хууль сахиулах байгууллагын үзэн ядалтаас үүдсэн гэмт хэрэгт авах арга хэмжээ хийгээд хүй олныг тодорхойлоход хэвлэл мэдээлэл чухал үүрэг гүйцэтгэдэг.** Зарим

тохиолдолд, орон нутгийн хууль хүчний байгууллагууд ЛГБТИК хүмүүсийн эсрэг үзэн ядалтын гэмт хэргийг маш доогуур эрэмбэлсэн хэвээр байна.

Үүний үр дүнд цагдаа нар тухайн хэргүүдийг анхааралтай эрэн сурвалжлахгүйгээр зогсохгүй бүрмөсөн орхиж, хохирогчдыг давхар хохироож, хэргийн тухай мэдээлэл авахыг хүссэн хохирогчийн ар гэрийнхэн болон олон нийтэд хариу өгөхгүй байж мэднэ. Ийм тохиолдолд медиагийн зүгээс үнэн бодит, яг таг мэдээллээр хангах нь үзэн ядалтын гэмт хэргүүдийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хууль сахиулагчдыг алагчлалгүй шударгаар ажиллахад түлхэц үзүүлж, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

Хэт барууны, үндсэрхэг үзэлтэй хүмүүсийн дийлэнх нь үзэн ядалтаас үүдсэн гэмт хэргийг ялих шалихгүйд тооцож, өөгшүүлдэг. Зарим хүмүүс, ялангуяа барууны үзэлтнүүд “бүх гэмт хэрэг бол үзэн ядалтын гэмт хэрэг” гэж ерөнхийлөх нь ч түгээмэл.

Уншигч, үзэгч, сонсогчдоо бодит баримтаар хангаж, ингэснээр тухайн гэмт хэргийн хохирогч бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээсээ болж халдлагад өртсөн эсэхийг мэдээлэл хүлээн авч буй хүмүүст өөрсдөө шийдэх боломж олгохыг бид та бүхнээс хүсэж байна.

Гэмт үйлдэл, халдлагын тохиолдлуудад ердөө ганцхан хохирогч байж болох ч гэм буруутай этгээдүүд ЛГБТИК хүмүүсийг хүчирхийлэл, халдлагын зохих ёсны бай гэсэн мессежийг түгээх санаа агуулж байдаг. (Бодит байдал дээр, ЛГБТИК гэж харагдсан гетеросексуал хүмүүс ч ЛГБТИК хүмүүсийн эсрэг үзэн ядалтын гэмт хэргийн хохирогч болох нь бий.) Тиймээс гэмт хэргийн тухай нарийн ширийн хийгээд нийгэмд үзүүлэх нөлөөний тухай мэдээлэхдээ хэргийн нотлох баримтан дээр тулгуурлахыг

зөвлөж байна.

**Гэмт хэргийн талаар үнэн бодит бус, ташаа мэдээлэх нь “гей түгшүүр”, “хохирогчийг буруутгах” гэх мэт ял шийтгэлээс мултрах гэсэн арга мэхийг санаандгүйгээр дэмжих магадлалтай.** ЛГБТИК

хохирогч өөр лүү нь дайрсан хэргийн үүрэг хариуцлагыг хуваалцах буюу цаад этгээд хүсээгүй янаг сэтгэл, сексийн хандлагаас зугтахын тулд (“гей түгшүүр”, “транс түгшүүр” ч гэж нэрлэгддэг арга мэх) халдлага үйлдсэн гэж гэмт үйлдлээ хаацайлах явдлыг хэзээ ч хүлээн зөвшөөрч болохгүй.

2013 оны наймдугаар сард Америкийн хуульч, өмгөөлөгчдийн холбооны зүгээс /American Bar Association/ дараах мэдэгдлийг гаргажээ. Үүнд: “... Америкийн хуульч, өмгөөлөгчдийн холбооноос хохирогчийн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжааг гэмт хэргийн шалтгаан нөхцөл болгон буруутгаж, халдлага үйлдэж, амь бүрэлгэсэн гэмт хэргийнхээ зарим хэсгийг, заримдаа бүр тэр чигт нь хаацайлах гэсэн ”Гей түгшүүр”, “транс түгшүүр” зэрэг шалтагийг үр нөлөөгүй болгож, цаашилбал хэрэглэх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авахыг улсын, мужийн, орон нутгийн болон бүс нутгийн удирдлагуудад уриалж байна” гэсэн юм.



## АНХААРВАЛ ЗОХИХ

## Өртөлтийн өмнөх урьдчилан сэргийлэлт (ӨӨС) ба өртөлтийн дараах урьдчилан сэргийлэх эмчилгээ (ӨДС)

**ХДХВ халдварлах нь тодорхой нэг бэлгийн чиг баримжаатай шууд холбоотой биш бөгөөд гагцхүү өндөр эрсдэлтэй зан үйлээс хамаардаг.** Эрсдэлтэй бүлэгт шууд ЛГБТИК хүмүүсийг хамруулах, эсвэл ердөө ижил хүйсийн хүнтэй бэлгийн харилцаанд орсноор ХДХВ-ын халдвар авах эрсдэл өснө гэж тусгахаас зайлсхийгээрэй.

**Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвөөс (Centers for Disease Control & Prevention) “ЭБЭ” буюу “эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд” хэмээх товчилсон үгийг анх гаргажээ. Энэ нь анагаахын болон статистикийн тодорхой бичвэрүүдийн хүрээнд ашиглагдахаас бусдаар гей, бисексуал эрчүүд, өөрсдийгөө гей, бисексуал гэж тодорхойлдог хувь хүн, бүлэг хүнийг нэрлэхэд хэрэглэгдэхгүй.** Харин уг тодорхойлолт өөрийгөө гей эсвэл бисексуал гэж тодорхойлдоггүй боловч эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тухай дүрслэхэд хамгийн дөхөм юм.

**ЛГБТИК хүмүүс бусдыг бодвол ХДХВ-ын халдвар авах эрсдэл өндөртэй гэсэн утгатай үг хэллэг ашиглахаас сэргийлээрэй.** Жишээлбэл, “нийт хүн ам”-д хандсан зөвлөмжүүд, өргөн

хүрээнд явуулах урьдчилан сэргийлэлт болон эмчилгээний арга замууд гей, бисексуал, күйр эсвэр ЭБЭ хүмүүсийнхээс өөр, тусдаа мэт ойлголт өгдөг.

**ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх арга замуудыг том зургаар дүрслэн харуулахдаа ӨӨС болон ӨДС-ийг хамт дурдах хэрэгтэй.** ӨӨС нь ХДХВ-гийн хариу сөрөг гарсан хүмүүст ХДХВ-д өртөхөөс сэргийлж өгдөг эм юм. Холбооны Засгийн газар ӨӨС-ийг ХДХВ тусах өндөр эрсдэлтэй бүлгийн хүмүүст бичиж өгөхийг зөвлөдөг.

Харин ӨДС нь ХДХВ-гийн сөрөг хариутай хүмүүс ХДХВ-д өртсөн тохиолдолд тэр даруй яаралтай хэрэглэх эм юм. Энэхүү эмийг өртөлтийн дараах 36 цагийн дотор хэрэглэвэл илүү үр дүнтэй бөгөөд ерөнхийдөө 72 цагаас хэтрэлгүй хэрэглэх ёстой. ӨӨС, ӨДС-ийн хэрэглээний тухай ойлголт нэмэгдэж, тогтмол шинжилгээ, бэлгэвчийн хэрэглээ, шинэ зүү тариурын хүртээмж болон бэлгийн нэг хавьтагчтай байх явдалтай нэгдсэнээр ХДХВ-ын тархалт эрс буурах боломжтой.



Хэдийгээр бэлгийн чиг баримжаанаас үл хамааран халдвар авах эрсдэл, хүчин зүйлүүд их байгаа боловч Холбооны Засгийн газрын зүгээс өөрийгөө гей болон бисексуал гэж тодорхойлдог эрчүүдийг гагцхүү сүүлийн нэг жилийн турш бэлгийн хавьталд ороогүй тохиолдолд цусаа хандивлахыг зөвшөөрдөг. 2015 оны арванхоёрдугаар сард Холбооны Засгийн газар гей, бисексуал эрчүүдийг цус хандивлахыг бүр мөсөн хориглодог байсныг өөрчилсөн нь энэ. Гэсэн хэдий ч уг шинэчилсэн хууль бэлгийн идэвхтэй амьдрал бүхий гей, бисексуал залуучуудыг гадуурхаж байгаа юм. Энэхүү утгагүй хуулийн заалтаас үүдэж сая сая эрчүүдийн хандивлаж болох цусны нөөц хангамжийг шууд боосон эрсдэл үүсч буйг нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн зарим мэргэжилтнүүд шүүмжилдэг. Гей, бисексуал эрчүүд өөрсдийн эд эс, эрхтэнг хандивлахад ч үүнтэй адил олон төрлийн хоригтой тулгардаг.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

ЛГБТИК хүмүүсийг эсэргүүцэн тэмцэгчид бэлгийн чиг баримжааг сонголт хэмээн зарлаж, өөрчлөх боломжтой тухай олон жилийн турш маргасаар ирсэн билээ. Гэвч тэднийхээр энэ нь гетеросексуал хүмүүс бус, зөвхөн ижил хүйсийн хүмүүст хамаатай аж. Түүнчлэн “ижил хүйстэн байх нь” жинхэнэ бодит зүйл биш агаад сэтгэцийн өвчний нэг хэлбэр, эсвэл сэтгэл засал, шашны аргаар “эдгээх” боломжтой сэтгэл санааны хямрал гэж тэд мэдэгдэх нь түгээмэл. Бэлгийн цөөнхийг эсэргүүцдэг хүмүүс ижил хүйсийн хүндээ татагдах нь эмчлэгдэх боломжтой учраас ЛГБТИК хүмүүст хууль, эрх зүйн орчинд тэгш эрх хэрэггүй, ялгаварлан гадуурхахаас хамгаалах шаардлагагүй гэж үздэгийн учир энэ.

Сүүлийн үед иймэрхүү хөтөлбөрүүд хяналт шалгалтад өртөх нь ихэссэн. Энэ чиглэлийн хөтөлбөрүүд дотроос хамгийн өргөн цар хүрээтэй нь болох “Эксодус” 2013 онд бүрмөсөн хаагдахдаа уг хөтөлбөрт хамрагдсан хүмүүст хор хөнөөл учруулсныхаа төлөө уучлалт гуйжээ. Үүн дээр нэмж дурдахад, бусад “экс гей” хөтөлбөрүүдийн эсрэг шүүхийн зарга мэдүүлсээр байгаа бөгөөд бэлгийн чиг баримжаа өөрчлөх амлалтаа биелүүлээгүй төдийгүй оролцогчдодоо хэмжээлшгүй их хор хохирол учруулсныг дурдсан байдаг.

### **Америкийн сэтгэл зүйчдийн холбоо**

Америкийн сэтгэл зүйчдийн холбоо “ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг эмчлэх” явдлыг буруушаан эсэргүүцэхдээ “Өөрчлөх эмчилгээнээс болж сэтгэл гутрал, түгшүүр зовнил, өөртөө хор хохирол учруулах зан үйл гэх мэтчилэн сөрөг үр дагавар ихээр үүсдэг бөгөөд тухайн засалч ижил хүйстнүүдийн эсрэг үзэл бодолтой уялдаж ажилладаг учраас “өвчтөн” хэмээн тодорхойлж буй үйлчлүүлэгчийнхээ аль хэдийн мэдэрч туулсан өөрийгөө үзэн ядах сэтгэлийг улам өрдөх аюултай” гэж тайлбарласан юм.

### **Америкийн сэтгэл зүйчдийн холбооны тайлан (2009 он)**

Америкийн сэтгэл зүйчдийн холбооны /АРА/ ажлын хэсэг бэлгийн чиг баримжааг сэтгэл заслын аргаар өөрчлөх явдлын талаар маш чухал тайланг урьдчилсан байдлаар гаргасан

юм. Тус холбооны тодорхойлсноор “бэлгийн чиг баримжаа өөрчлөх оролдлогууд” /SOCE/-ыг мэргэжил нэгтнүүдээр хянуулж, бүх талын судалгаа шинжилгээ хийсний эцэст “бэлгийн чиг баримжаа өөрчлөх оролдлогууд нь амжилттай болох янзгүй байгаад зогсохгүй хэрэгжүүлэгч, дэмжигчдийнх нь өгүүлдгээс эсрэгээрээ аюул, хор хөнөөл учруулах эрсдэлийг агуулдаг” гэсэн дүгнэлтэд хүрчээ. АРА-гийн удирдах байгууллагын 125-4 гэсэн үнэмлэхүй саналаар уг тайлангийн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхээр болсон юм. Түүнчлэн Америкийн эмнэлгийн холбоо, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний нийгэмлэг, Америкийн хүүхдийн эмч нарын академи лесбиян, гей, бисексуал хүмүүсийг “анагаах” оролдлогуудын эсрэг дуу хоолойгоо нэгтгэсэн билээ.

## **Мужууд насанд хүрээгүйчүүдэд зориулсан “Өөрчлөх эмчилгээ”-г хориглож эхэллээ.**

ЛГБТИК-ийн эсрэг тэмцэгчид үнэхээр өөрийгөө өөрчилж, шашны итгэл бишрэлтэйгээ нийцэж амьдрахыг чин сэтгэлээсээ хүссэн хүмүүст л тусалдаг бөгөөд зөвхөн тэдэнд өөрсдийн хөтөлбөрийг санал болгодог гэж мэтгэдэг. Гэвч “Өөрчлөх эмчилгээ”-ний хөтөлбөрт өөрийн хүслээс ангид хамрагдсан олон хүүхэд бий. Шашны удирдагчид нь хүүхдээ өөрчлөх ёстой гэж ухуулснаас үүдэж эцэг эхчүүд насанд хүрээгүй хүүхдүүдээ иймэрхүү хөтөлбөрүүдэд хүчээр элсүүлсэн нь тэр. Тэгвэл хэд хэдэн муж насанд хүрээгүй хүний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийг өөрчлөх гэж оролдсон эл хөтөлбөрүүдийн учруулдаг хор нөлөөг судалж эхлээд буй. Уг зөвлөмжийг бичих явцад Калифорни, Иллиной, Нью-Жерси, Нью-Йорк, Орегон, Вермонт муж болон Колумбиа дүүрэг 18-аас доош насны хүнийг “эмчлэх” гэсэн хор хөнөөлтэй явдлыг зогсоох тал дээр чухал алхмуудыг хийгээд байна.

## **Нэр томьёо**

“Өөрчлөх эмчилгээ”, “засах эмчилгээ” гэдэг тодорхойлолтыг хэрэглэхдээ хашилтад авах нь зүйтэй. Учир нь эдгээр нэр томьёо ижил хүйсийн хүндээ татагддаг болон трансжендэр хүмүүсийг “гаж”, “буруу” эсвэл “сэтгэцийн өвчтэй” тул “эмчлэгдэх” ёстой гэсэн давхар утгыг агуулж байдаг. Тэгэхээр ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллийг өөрчлөх гэсэн хандлага, оролдлогуудын талаар өгүүлэхдээ тэдгээрийн цаад санаа, үйдлийг тодорхойлох нь хамгийн

энгийн шийдэл юм.

## **Өөрчлөх эмчилгээг давж гарагсад**

Энэ төрлийн эмчилгээ, хөтөлбөрүүдийн тухай аль ч түүхийг өгүүлэхдээ тэдгээрийг давж гарсан хүмүүсийн өнцгийг зайлшгүй оруулах хэрэгтэй. “Өөрчлөх эмчилгээ”-г дэмжигчдийн “амжилттай түүх” бүрийн цаана огт өөрчлөгдөөгүй үлдсэн зуу зуун хүн бий. Тэр бүү хэл харин ч эсрэгээрээ сэтгэл зүйн гэмтэл, сэтгэлийн шарх, сэтгэл гутралд оруулж, амиа хорлох тухай бодол төрүүлснээр барахгүй үйлдэл хийхэд хүргэжээ. Тиймээс “Beyond Ex-Gay”-тэй адил төстэй сүлжээнүүд экс-гей хөтөлбөрүүдэд хамрагдаж байсан хохирогчдын сэтгэл зүйг эдгээх, дэмжлэг үзүүлэх зорилгоор бий болсоор байна. “Beyond Ex-Gay” сүлжээ экс-гей хөтөлбөрүүдийг давж гарсан хүмүүсийн дунд томоохон судалгаа явуулсан агаад тус сүлжээний сайтаас судалгааны үр дүнтэй танилцаж болно.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

Сүүлийн жилүүдэд, спортын соёл, хомофоби, трансфоби болон ЛГБТИК тамирчдын төвөгтэй огтлолцол спортын шүтэн бишрэгчид хийгээд спортын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн дунд халуун сэдэв болж эхлээд байна. Тамирчид, дасгалжуулагчдын хэлсэн ЛГБТИК хүмүүсийн эсрэг үг яриа, зарим тамирчдын бэлгийн чиг баримжааны тухай таамаглалууд, Олимпийн медалт Том Дали, Кейтлин Женнер, Үндэсний хөлбөмбөгийн лигийн /NFL/ тоглогч асан Майкл Сэм, Үндэсний сагсан бөмбөгийн лигийн /NBA/ тоглогч асан Жейсон Коллинс, Пуэрто Рикагийн боксчин Орландо Круз, хөлбөмбөгчин Робби Рожерс, Уэльсийн регбичин Гарет Тома, Нэгдсэн улсын олимпын багийн хөлбөмбөгчин Меган Рафино гэх мэт тамирчдын бэлгийн чиг баримжаагаа ил зарлан кам-аут хийсэн түүхүүд энэхүү сэдвийн хүрээнд үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг өрнүүлэхэд хүргэж, шуугиан дэгдээж чадсан юм. Мартина Навратилова, Билли Жин Кинг, Грег Луганис, Жонни Вейр зэрэг теннис, шумбалт, уран гулгалтын тамирчид хүй олны нүүр тулгардаг асуудлаар ЛГБТИК тамирчид дуу хоолойгоо хүргэдэг болох эхлэлийг анх тавьсан билээ.

### **Мэргэжлийн спортын ертөнц урьд байгаагүйгээр нээлтэй болж, бэлгийн болон хүйсийн цөөнхийг хүлээн зөвшөөрөх хандлагатай болжээ.**

Олон дасгалжуулагч, менежер, тоглогчид багт нь ЛГБТИК хүмүүс байгаа гэдгийг ухамсарлаж эхэлж буй бөгөөд цөөнгүй хэсэг нь өөрсдийгөө энэ талын мэдээллээр хангаж, ойлголтоо нэмэгдүүлэх хийгээд ЛГБТИК тамирчдад ээлтэй орчин бүрдүүлэх алхмуудыг хийж байна. Бен Кохен, Брайн Бурке, Хадсон тейлор зэрэг спортын хүрээн дэх нээлтэй стрэйт дэмжигчид ЛГБТИК тамирчид, цөөнх тамирчидтай мэргэжлийн багуудыг дэмжиж буйгаа илэрхийлэх зорилгоор StandUp Foundation, Athlete Ally хэмээх ашгийн бус бүлгүүдийг тус тус үүсгэн байгуулсан юм. Зуу зуун мэргэжлийн тамирчид “You Can Play”, “It Gets Better” зэрэг нийгмийн рекламуудад оролцож, ЛГБТИК тамирчид, шүтэн бишрэгчдээ ил тод дэмжиж буйгаа илэрхийлсэн нь бий.

Спортын багуудыг эзэмшдэг корпорацийн эзэд ч гэсэн бизнесийн түншүүдийнхээ манлайллыг дагаж, ЛГБТИК хүй олныг албан ёсоор дэмжиж буйгаа илэрхийлэх болжээ. Мэргэжлийн лигүүд ЛГБТИК сэдвүүдийн хүрээнд ажилтнууд, тоглогчдоо мэдээллээр хангах тал дээр идэвхтэй ажиллаж байгаа. Тухайлбал, NHL, NFL, NBA шинэ хүмүүстээ зориулж энэ чиглэлийн симпозиум зохион байгуулдаг. 2014 оны долдугаар сард, MLB-ын зүгээс спортын ертөнцөд ЛГБТИК хүмүүсийг бүрэн хамруулах хөтөчийн үүрэг гүйцэтгүүлэхээр гей гэдгээ нийтэд зарласан хуучин тоглогч Билли Бинийг зөвлөхөөр томилсон юм.

Гэвч зарим тамирчин, спортын мэргэжилтнүүд өөрсдийнх нь багт ЛГБТИК хүн байхгүй гэж олон нийтэд зарлахын сацуу голдуу гей эрчүүд рүү чиглэсэн битүү хатуу утгатай үгс, хувцас солих өрөөний маазралаар дамжуулан ажлын сөрөг орчныг үүсгээд буй.

Эмэгтэйчүүдийн коллежийн спортын хувьд сөрөг элсэлт буюу дасгалжуулагчид сайн тамирчдыг өрсөлдөгч сургуульд алдахгүйн тулд ЛГБТИК-ийн эсрэг агуулгатай мессеж түгээх аргыг ашиглах явдал түгээмэл асуудал болоод байна. Үр дүнд нь ЛГБКТ тамирчдын дийлэнх нь институтын түвшний доромжлол тохуурхал, ялгаварлан гадуурхалтаас болж нуугдсан хэвээр үлдэж байна.

**Тоглогчдыг тоглохыг нь зөвшөөр.** ЛГБТИК тамирчид мэргэжлийн түвшинд тоглож буйг хүлээн зөвшөөрөх нь харьцангуй шинэ үзэгдэл агаад ЛГБТИК хүмүүсийн талаар хэвшмэл буруу ойлголтуудыг устгахаар ажиллах нь чухал байгаа. Нөгөөтэйгүүр, ямар ч тамирчны эхний бөгөөд хамгийн чухал үүрэг бол ерөөсөө л тоглож, тухайн спортдоо амжилт гаргах гэдгийг ойлгох нь бас чухал. Бүтээхээр эрмэлзэж буй төгс ертөнцөд, NFL эсвэл NBA-гийн ЛГБТИК тоглогч алагчлал, ялгаварлан гадуурхалттай нүүр тулахгүйгээр, ЛГБТИК асуудлуудын талаар өөрийг нь байнга шалгаах нөхцөл байдалд орохгүйгээр эрх тэгш тоглох юм.

**Спортын түвшин бүрийн гол тоглогчид.** Спортын бүхий л түвшний тамирчид олноороо кам-аут хийж байгааг үл харгалзан зөвхөн мэргэжлийн болон Олимпийн багийн тамирчдад гол анхаарал хандуулдаг үзэгдэл түгээмэл. Тиймээс ЛГБТИК хүн гэдэг утгаараа өөрсдийн түүхийг хуваалцахыг хүсэж буй ахлах сургуулийн, коллежийн түвшний тамирчдын дуу хоолойг эрж хайх тухай бодож үзээрэй. Коллежийн бисексуал хөлбөмбөгчин Коннер Мертенз, ахлах

сургуулийн багийн трансжэндэр дасгалжуулагч Стефен Александр шиг хүмүүсийн түүхүүд тухайн орон нутгийн иргэдийг мэдээллээр хангаад зогсохгүй ЛГБТИК тамирчин, дасгалжуулагчдыг хүлээн зөвшөөрөхөд нь туслах үр нөлөөтэй.

**ЛГБТИК тамирчдын тухай сэдвийг хөндөхдөө багийн спортууд ЛГБТИК тамирчидтай учраа олох боломжгүй гэж мэтгэдэг хүмүүсийн өнцгөөс давах хэрэгтэй.** Зарим спортын сэтгүүлч, дасгалжуулагч, менежер болон тамирчид ЛГБТИК хүмүүс багийн спортод нээлттэй тоглох боломжгүй гэдэг. Сэтгүүлчид тухайн тоглогч кам-аут хийхийг сонгосон тохиолдолд үүсэх хүнд хэцүү, сөрөг нөлөөнүүдийг уг асуудалтай холбон ямагт дурдан бичих замаар уг ташаарлыг улам бататгах тохиолдлууд бий. Тиймээс энэ сэдвийн хүрээнд мэдээ сурвалжлага бэлтгэхдээ дээр дурдсан санаа бодлыг сорихуйц спортын салбарын бусад хүмүүсийн дуу хоолойг оруулахыг эрэмэлзэх хэрэгтэй. Аль болох олон тоглогч кам-аут хийснээр тэд хүлээж авсан эерэг хандлагууд хийгээд ЛГБТИК гэдгээсээ болж ажлаа алдахаас айх, ичгүүргүйгээр тоглохын ашиг тустай талуудыг хуваалцах боломжтой болох нь дамжиггүй.

**Мэргэжлийн тамирчид, менежерүүд, дасгалжуулагчдаас ирэх ЛГБТИК хүмүүсийн эсрэг утгатай сэтгэгдлүүдийг нийгмийн дүр төрх болсон бусад хүмүүсийн төстэй мэдэгдлүүдтэй ижил түвшинд авч үзэх нь зүйтэй.** Сонгогдсон

гишүүд төлөөлөгч, эсвэл Холливудын алдартан ЛГБТИК хүмүүсийн эсрэг нэр томъёо ашигласан тохиолдолд шүүмжилсэн агуулгатай мэдээ нийтлэлүүд өргөн хүрээнд тархдагтай адил спортын алдартнууд, гол төлөөлөгчдийн ЛГБТИК тэгш эрхийн эсрэг санаатай, үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтын уур амьсгалыг өрдсөн үг яриаг судлан шинжилж, хэлэлцэн дүгнэх хэрэгтэй.

**Трансжендэр тамирчид үл мэдэхээс үүдсэн эсэргүүцэлтэй нүүр тулгардаг.** Трансжендэр хүмүүс, ялангуяа трансжендэр эмэгтэйчүүд спортод хүч сорих тухай асуудал дээрх нийгмийн болон медиагийн хариу үйлдэл ихэвчлэн сөрөг хандлагатай бөгөөд шинжлэх ухааны баримтаар батлагдаагүй байдаг. Аливаа трансжендэр хүн “шударга бус давуу тал”-тай эсэх дээр санал бодлоо хэлж буй хүмүүс голдуу “зөн совин”-доо тулгуурладаг. Гэтэл зөн совин гэдэг шинжлэх ухаан биш. Олон улсын олимпийн хороо (ОУОХ), Үндэсний коллежийн хөнгөн атлетикийн холбоо (NCAA), Эмэгтэйчүүдийн спортын сан (WSF) зэрэг спортын удирдах байгууллагууд дааврын эмчилгээний шилжилтийг шинжлэх ухааны үүднээс судалсны дүнд тодорхой мэдэгдэл гаргасан юм. Тус мэдэгдэлд

трансжендэр тамирчдын эрхийг хамгаалаж, бүгдэд ээлтэй, тэгш, шударга нөхцлөөр хангахыг дэмжжээ. Трансжендэр тамирчдын талаар бичихдээ дааврын эмчилгээ спортын бэлтгэлд хэрхэн нөлөөлдгийг сүүлийн үеийн анагаах ухааны болон хууль эрх зүйн судалгаа, мэдээллээс ашиглахыг хүсье.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## **ЛГБТ Төвөөс орчуулж эрхлэн гаргасан бусад материалууд:**

- “Амьдрал Эрх чөлөө Хайрын магтуу” Дэлхийн шилдэг ЛГБТ яруу найргийн антологи. Н. Анараа
- “Ното Liber” эссэ зохиол А. Зориг
- Транссексуал, трансжендэр болон хүйсийн хэмшмэл байдалд үл багтах хүмүүсийн эрүүл мэндийн ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ. Дэлхийн Трансжендэр эрүүл мэндийн мэргэжлийн холбоо
- “Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллах удирдамж” Америкийн сэтгэл зүйн нийгэмлэгээс сэтгэл зүйчдэд зориулсан гарын авлага
- ЛБТИ хүний эрх” Нийгмийн ажилчдад зориулсан гарын авлага
- “ЛГБТИ хүний нөөц” Хүний нөөцийн ажилчдад зориулсан гарын авлага
- “Миний найз ЛГБТ” комик гарын авлага
- “Тэр гараг” сэтгүүл
- Бэлгийн цөөнхийн тухай асуугддаг түгээмэл асуултауд
- Genderbread - Бэлгийн чиг баримаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн зурагт тайлбар
- Жогжакартын зарчмууд
- “Үзэн ядалтын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх нь” практик гарын авлага
- “Хайр бол хайр” манга ном

Эдгээр ном, гарын авлагуудаас авах бол бидэнтэй 70110323 дугаараар эсвэл [info@lgbtcentre.mn](mailto:info@lgbtcentre.mn) хаягаар холбогдоорой.



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН